

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ
ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ”-
ИЙН ХЭРЭГЖИЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

хамтран хэрэгжүүлж буй

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИНСТИТУТЫН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

захиалан санхүүжүүлсэн

ФИЛАНТРОПИ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ТӨВ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
ҮНДЭСНИЙ ХОЛБОО

хамтран хэрэгжүүлсэн

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ
ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ”-
ИЙН ХЭРЭГЖИЛТ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

ФИЛАНТРОПИ Хөгжлийн төлөө Төв

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 27,
Залуучуудын хөгжлийн Полиси төв 5 тоот

Утас: 976-11-316543

Шуудангийн хаяг: Улаанбаатар шуудан 103
Шуудангийн хайрцаг: 10310010

Вэб хуудас: <http://www.philanthropy.org.mn>
<http://www.businessdata.mn>

Цахим шуудан: philanthropy@mongol.net
monitoring@consultant.com

ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, 25.1 байр

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	7
БҮЛЭГ 1. ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ	9
1.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн танилцуулга	10
1.2 Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлын судлагдсан байдал	10
1.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн хэрэгжилтийн байдал	12
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	15
2.1 Судалгааны арга зүй	16
2.2 Үндсэн ойлголтын тайлбар	17
2.3 Судалгааны төслийн багийн танилцуулга	18
2.4 Төслийн тайлангийн бүтэц	19
БҮЛЭГ 3. ТЭГШ ОРОЛЦООНЫ УГТВАР НӨХЦӨЛ БАЙДАЛ	20
3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш оролцооны тухай ойлголтыг нэмэгдүүлсэн байдал	21
3.2 Үр дүнтэй эмнэлгийн тусламж	23
3.3 Сэргээн засалтын үйлчилгээ	24
3.4 Туслах хэрэгсэл, үйлчилгээ	26
БҮЛЭГ 4. ЗОРИЛТОТ САЛБАРУУД ДАХЬ ТЭГШ ОРОЛЦООНЫ БАЙДАЛ	27
4.1 Бие бялдарын хийгээд мэдээлэл, харилцаа холбооны орчны хүртээмж	28
4.2 Боловсролыг интеграцчилсан түвшинд эзэмших байдал	29
4.3 Хөдөлмөр эрхлэлтийн байдал	30
4.4 Орлого олох болон нийгмийн хамгаалал	31
4.5 Хувийн эрх чөлөөний байдал: гэр бүл	34
4.6 Соёл, спорт ба чөлөөт цагаа өнгөрөөх	35
4.7 Шашин шүтлэг	36

БҮЛЭГ 5. АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙДАЛ	37
5.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдээлэл ба судалгаа	38
5.2 Бодлого боловсруулах, төлөвлөх	39
5.3 Хууль тогтоомж	41
5.4 Эдийн засгийн бодлого	42
5.5 Ажлын зохицуулалт	43
5.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд	44
5.7 Хүний нөөцийн сургалт	44
5.8 Хөтөлбөрийн үндэсний үнэлгээ ба хяналт	45
5.9 Хамтын ажиллагаа	46
ДҮГНЭЛТ	47
ЗӨВЛӨМЖ	51
ХАВСРАЛТ	53
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	54

ӨМНӨХ ҮГ

1993 онд хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48 дугаар чуулганаас баталсан Тахир дутуу хүмүүст /Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст/ тэгш боломж олгох Стандарт дүрмийг баталсан бөгөөд 200 гаруй жилийн хөгжлийн үр дүнд бүрэлдэн тогтсон хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд нийгмийн бусад гишүүдийн адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээх өнөөгийн бодлогыг баталгаажуулахад оршжээ.

Стандарт дүрмийн хэрэгжилтийн байдлыг тодруулах ажлыг тус төвийн судлаачдын баг Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбооны багийн хамтаар гүйцэтгэсэн бөгөөд төслийн хүрээнд харьцангуй богино хугацаанд асар их мэдээлэлд үндэслэн үнэлгээ хийхээр ажилласан болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн олон улсын стандартын хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх хариуцлагатай ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн холбогдох байгууллагууд болон хувь хүмүүст талархсанаа илэрхийлье.

Сайн үйлс дэлгэрэх болтугай

Д.Сүнжид

Төслийн багийн ахлагч

Филантропи хөгжлийн төлөө
төвийн гүйцэтгэх захирал

Ц.Оюунбаатар

Төслийн багийн зөвлөх
Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн
Байгууллагуудын Үндэсний Холбооны
ерөнхийлөгч

УНН
СУДАЛГААНЫ САН

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АИФО	РАУЛ ФОЛЕРОГИЙН АНД НӨХДИЙН ХОЛБОО
АХБ	АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
БЗД	БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ
БСШУЯ	БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БХБЯ	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БТСУХ	БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО
ДЭМБ	ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА
ДБ	ДЭЛХИЙН БАНК
ЕТГ	ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР
ЗГ	ЗАСГИЙН ГАЗАР
ЗТАЖЯ	ЗАМ ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
МССЗҮТ	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, СЭРГЭЭН ЗАСАЛТЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
МТДЭХ	МОНГОЛЫН ТАХИР ДУТУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБОО
МТСХЭАХН	МОНГОЛЫН ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ НИЙГЭМЛЭГ
МУ	МОНГОЛ УЛС
МУИС	МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МХБИБҮХ	МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО
МЭ	МОН ЭДЮКЕЙШН КОНСАЛТИНГ
НЗДТГ	НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
НДЕГ	НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ННФ	НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ
НҮБ	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА
НҮБХХ	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
НҮБХАС	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮН АМЫН САН
НХОТСЗ	НИЙГЭМ ХАМТ ОЛОНД ТУЛГУУРЛАН СЭРГЭЭН ЗАСАХ
НХХЯ	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ
ОНРТ	ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗ
ОУБ	ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
ОУХБ	ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА
СӨБ	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ
СХД	СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ
ТББ	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

ҮСГ	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗАР
ХБИ	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД
ХБХЭЭХ	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХИЙН ХОЛБОО
ХБИБ	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БАЙГУУЛЛАГА
ХУД	ХАН-УУЛ ДҮҮРЭГ
ХХК	ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ХХҮГ	ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ХЭҮК	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС
ШУТИС	ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭМЯ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭМНХЯ	ЭРҮҮЛ МЭНД НИЙГМИЙН ХАМГААЛАЛ ЯАМ
ЭМШУИС	ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ
ЭХМК	ЭМНЭЛЭГ, ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ КОМИСС

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮЛЭГ 1.

ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1.1 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРМИЙН ТАНИЛЦУУЛГА

Тахир дутуу хүмүүст тэгш боломж олгох Стандарт Дүрмийг 1993 оны 12 сарын 20-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48 дугаар чуулганаар баталсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх тэгш байх тухай дэлхий дахины үйл ажиллагааны хөтөлбөрт дурьдсан тодорхой арга хэмжээнүүдийг удирдлага болгож

- a) Хөгжлийн бэрхшээлд хамаарах салбарт авч байгаа бүх арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын нөхцөл, тусгай хэрэгцээний талаар бүрэн, дүүрэн сайн мэдлэг туршлагатай байх
- b) Нийгэм эдийн засгийн нэг үндсэн зорилго нь бүх хүнд нийгмийн амьдралын аль ч салбарт хүрэх боломж олгохыг цохон заах
- c) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар нийгмийн бодлогын чухал талуудыг, түүний дотор шаардлагатай тохиолдолд техник эдийн засгийн хамтын ажиллагаанд үзүүлэх идэвхтэй тусламж дэмжлэгийг тодорхойлох
- d) Техник, эдийн засгийн хөгжил, улс төр, соёлын амьдралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст оролцох эрх үүргийг харгалзан энэ үйл ажиллагааг явуулах олон хувилбарт санал дэвшүүлэх
- e) Улс орнууд, НҮБ-ын системийн байгууллагууд, засгийн газар хоорондын бусад байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын хоорондын нягт хамтын ажиллагааг хангах үндэсний механизмуудыг
- f) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст адил тэгш боломж олгох талаар улс орнуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээг хянах үр ашигтай механизмыг

санал болгох зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст адил тэгш боломж олгох зарчмыг баталсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн олон улсын стандарт дүрэм нь

1. Тэгш оролцооны угтвар нөхцөл байдлыг бүрдүүлэх
2. Тэгш оролцооны зорилтот салбаруудын үйл ажиллагаанд тусгах
3. Тэгш оролцооны арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

1.2 МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АСУУДЛЫН СУДАЛГАДСАН БАЙДАЛ

Манай улсын нийт хүн амын 5 орчим хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг гэсэн тоо баримт байдаг ч албаны эх сурвалжаас гаралтай зарим тоо баримтууд зөрөх байдал их байдаг.

2004 онд явуулсан Үндэсний Статистикийн Газрын бүртгэл, түүвэр судалгаагаар нийт хүн амын 2.8 хувийг /69263/ хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг байна. Нэг удаагийн түүвэр судалгаа нь Азийн Хөгжлийн Банкны Нийгмийн статистикийг боловсронгуй болгох ТА-3684 төслийн хүрээнд хийгдсэн бөгөөд манай улсын хэмжээнд хийгдсэн хөгжлийн бэрхшээлтэй

иргэдтэй холбогдох судалгаануудаас цар хүрээгээрээ харьцангуй том нь юм. Энэ судалгааны үр дүнгээс холбогдох зарим тоон мэдээллийг дурдъя.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 55.2 хувийг эрэгтэйчүүд үлдсэн 44.8 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд тэдний 50.1 хувь нь хөдөө орон нутагт амьдардаг байна.¹ Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 35.5 хувь нь төрөлхийн үлдсэн хэсэг нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй аж.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь ангилан үзвэл дотор эрхтний 22.5 хувь, бие эрхтний 12.5 хувь, оюуны хомсдол 7.9 хувь, харааны бэрхшээлтэй 6.8 хувь тус тус байна.

Түүнчлэн олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 62.6 хувь нь ердийн өвчнөөр, 3.9 мянга буюу 8.7 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөр, 2.7 хувь нь үйлдвэрлэлийн ослоор, 10.2 хувь нь бусад шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй болжээ.

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 20.5 хувь нь бүрэн бус дунд, 19.5 хувь нь бага боловсролтой бөгөөд боловсролгүй хүмүүсийн 72.6 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаагаас харахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын асуудал манайд зайлшгүй чухалчлан үзэх асуудал болсон ажээ.

15 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 36.1 хувь нь ямар нэг мэргэжил эзэмшсэн боловч 26.4 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байна. Тэдгээрийн 56.9 хувь нь хувиараа ажиллагч, 16.4 хувь нь гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч, 12.8 хувь нь гэрээгээр ажиллагч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 88.4 хувь нь эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлийн зэргээ тогтоолгосон байхад 8000 гаруй иргэд буюу 11.6 хувь нь тогтоолгоогүй байна.

Түүнчлэн энэхүү судалгаанд хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 22,6 хувь нь л нийгмийн халамжийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлдэг хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагддаг гэсэн бөгөөд үлдсэн 77,4 хувь нь буюу 2057 иргэн энд хамрагдаж чаддаггүй гэжээ.

Италийн засгийн газрын бус АИФО байгууллагаас явуулсан судалгааны дүнгээс дурьдахад манай улсад нийт хүн амын 4.8 хувь буюу 115 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа бөгөөд тэдний 65 хувь нь эмэгтэйчүүд бол 34000 хүүхэд байдаг гэжээ.

2005 онд Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын санхүүжилтаар хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн асуулгын судалгааны үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй таван хүн тутмын хоёр нь нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй гэсэн байна.

Судалгааны дүнгийн зөрүүтэй байдлууд нь аргазүйгээс илүү “хөгжлийн бэрхшээлтэй хүн” хэмээх ойлголтыг тодорхойлсон байдлаас хамаарч байна гэсэн дүгнэлтийг экспертүүд өгч байна.

Дээр дурьдсан судалгаануудаас гадна 1996 онд ОУХБ-аас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар хэрэгжүүлсэн судалгаа болон 1999 онд ЭМНХЯамны захиалгаар МУИС-ийн Социологийн тэнхмийн гүйцэтгэсэн “Тахир дутуу иргэдийн нийгмийн хэрэгцээ”, 2006 онд НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн зөн олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны хийж гүйцэтгэсэн “Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” зэрэг судалгаануудын үр дүнг харьцуулсан байдлаар мэдээллийн эх сурвалж болгон ашиглалаа.

¹ Үндсэн үр дүн: Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл, түүвэр судалгаа УБ., 2004

Түүнчлэн он, оны статистик тоо, албаны эх сурвалж бүхий тоо баримт, мэдээллүүд нь энэхүү стандартын хэрэгжилтийн байдалд үнэлэлт өгөхөд суурь мэдээлэл болсон юм.

1.3 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРМИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ТЭГШ ОРОЛЦООНЫ УГТВАР НӨХЦӨЛ БАЙДАЛ

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэсэн ойлголтын зөрүү байгаа бөгөөд олон улсын жишигт нийцсэн байдал хангалтгүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, энэ чиглэлээр ажил үйлчилгээ эрхэлдэг ажилтнуудын дунд ч зайлшгүй шаардлагатай мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа төдийгүй хүчин төгөлдөр үйлчилж байгаа төрийн бодлого, хууль тогтоомжид ч “тахир дутуу” хэмээх ойлголтуудыг хэрэглэсээр байна.
- Монгол Улсын төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой баталсан хууль дүрмүүдэд нийгмийн хандлага, ойлголтыг өөрчлөх, тэгш хамруулах нийгэм сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх тухай зохих хэмжээнд зааж өгсөн байна
- Монгол Улсын төрөөс олон улсын хийгээд олон нийтийн байгууллагуудтай хамтран тодорхой төсөл хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай нийгэмд зөв ойлголт, хандлага төлөвшүүлэх талаар арга хэмжээг цөөнгүй хэрэгжүүлж байгаа хэдий ч олон нийтийн дунд төдийлөн эерэг нөлөөлөл үзүүлж чадахгүй байна.
- Төрийн хууль тогтоомж, бодлогын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үр дүнтэй эмнэлгийн тусламжаар хангах асуудал тодорхой түвшинд хөндөгдөн орсон ч хэрэгжүүлэлтийн хэмжээнд цөөн хэдэн нэр төрөл, чиглэлийн хөтөлбөрөөр хязгаарлагдаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засалтын үйлчилгээгээр хангах тухай үндсэн харилцаа нь хууль эрх зүйн хийгээд төрийн бодлогын түвшинд баталгаажсан гэж болох ч энэ чиглэлээр хөгжлийн бэрхшээлийн бүх хэлбэрийг багтаасан үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн байдал нь учир дутагдалтай байна. Сэргээн засалт шаардлагатай бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү үйлчилгээг хүртэж чадахгүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн туслах хэрэгслийг ихэвчлэн Олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хүргэж байгаа ч нэр төрөл, тоо хэмжээний хувьд тэр бүр хангалттай байж чадахгүй байна. Нийгмийн Халамжийн Газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх тэргэнцэрийн нийлүүлэлтийн хэмжээ нь хангалттай ч чанарын асуудал тулгамдсан хэвээр байна.

ЗОРИЛТОТ САЛБАРУУД ДАХЬ ТЭГШ ОРОЛЦООНЫ БАЙДАЛ

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, харилцаа холбоог хүртээмжтэй болгох хууль эрх зүйн асуудлыг боловсронгуй болгоход цаашид анхаарах хэрэгтэй байгаа нь холбогдох хууль тогтоомжид хангалттай тусгагдаагүй буюу хэт ерөнхий байдлаар тусгасан байгаагаас харж болох юм.
- Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц байхгүй. 2004 онд Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” /БД 31-101-04/ -ийг баталсан бөгөөд мөн оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.
- Өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагддаг тусгай цэцэрлэг 3, сургууль 5, сургалт үйлдвэрлэлийн төв 1 нийслэл хотод ажиллаж байна. Ерөнхий боловсрол олгодог тусгай сургуулиудаас 4 нь оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгоход түлхүү анхааран ажилладаг боловч стандарт дүрэмд заасны дагуу хамгийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдийг бүрэн хамруулж чадахгүй байна.
- Интеграцчилсан сургалт явуулж буй сургалтын байгууллагуудад хүртээмж, туслах үйлчилгээнүүд хүрэлцэхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн сургалттай

сургуульд суралцахад нийгмийн хүлээн авалт болон тухайн хүүхдүүдийн сэтгэл зүйн бэлтгэл мөн хангалтгүй байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар /2006 оны нэмэлт өөрчлөлт/ тусгайлан баталгаажуулж өгсөн бөгөөд эдгээр хуульд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авах, ажиллуулаагүй тохиолдолд төлөх төлбөр хийгээд түүний зарцуулалт, ажлын цаг, хөдөлмөрийн нөхцлийн хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх хөнгөлөлт, мэргэжлийн сургалтаар мэргэжил эзэмшүүлэх тухай асуудлыг шийдвэрлэх боломжийг олгожээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрөөс бодлого, хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэхэд анхаарч байгаа ч хөдөлмөр эрхлэх боломжтой олон хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Энэ нь дээрх үйл ажиллагаанууд өргөн цар хүрээг хамарч чадахгүй байгаатай холбоотой, нөгөө талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх сэтгэлзүй хийгээд бие бялдрын хувьд бэлтгэх, нийгмийн хүлээн авалт, үнэлэмжийн асуудал багагүй нөлөөлж байгаа билээ.
- Монгол улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийг зохих орлоготой байхыг баталгаажуулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандсан нийгмийн хамгааллын чиглэлийн төрийн бодлогод иргэдийг зөвхөн халамжийн тэтгэвэр аваад суухаас илүүгээр ажил хөдөлмөр эрхлэхэд, нийгэм, хамт олны дунд идэвхтэй амьдрах, өөрсдийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг дэмжихэд анхаарсан бодлого хэрэгжүүлж үүнийгээ ч зохих хууль, тогтоомжийн хүрээнд баталгаажуулжээ. Хэдийгээр энэ нь хэтийн ирээдүйтэй бодлого ч өнөөдрийн нөхцөл байр сууринд нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг зөрчихгүй байхад чухалчлан цаашид үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд илүү ихээр анхаарах хэрэгтэй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүлтэй байж, тэжээн тэтгүүлэх, харгалзан дэмжүүлэх байдал эрх зүйн хүрээнд баталгаажсан нь харагдаж байна. Хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжийн хүрээнд удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй л биш бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд хувь хүний эрхийн дагуу гэрлэх, гэр бүлийн амьдрал зохиох эрхтэй ажээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн соёл, спортын үйл ажиллагаанд оролцохыг хуулиар баталгаажуулж өгсөн ч бодит байдал дээр энэ нь жигд хүртээмжтэй байж чаддаггүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь Монгол улсын иргэнийхээ хувьд нь шашин шүтэх, эс шүтэх үндсэн эрх, эрх чөлөөг эдлэх бөгөөд Онц болон дайны байдал зарласан тохиолдолд хүний амьд явах эрхийн адилаар итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хязгаарлахыг хориглосон байна.

АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙДАЛ

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар бодитой судалгаа хийхэд нэр томъёо, ойлголтын байдлыг нэн тэргүүнд цэгцлэх, олон улсын жишигт хүргэх нь чухал байна. Өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлын талаар нэгдсэн мэдээллийн сан байхгүй байна.
- Үндэсний түвшинд төлөвлөж хэрэгжүүлж буй төрийн бодлогуудад болон ерөнхий хөгжлийн төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлийн асуудлыг оруулж өгдөг бөгөөд орон нутгийн түвшинд үйл ажиллагааг дэмжихэд зохих байдлаар анхаардаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар баримталж буй төрийн бодлого хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, төрөөс нэгдсэн байдлаар цогц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэгч салбар нэгж, санхүүжилтын эх үүсвэр, төрийн бус хийгээд олон улсын байгууллагуудын хувь оролцоог тодотгон өгөх хэрэгцээ байна.
- Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно хэмээн Монгол Улсын Үндсэн хууль /1992/-д заасан бөгөөд хөдөлмөрийн чадвар алдах тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхийг баталгаажуулж өгчээ.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамаарах хууль тогтоомжуудыг хөгжлийн бэрхшээлийн асуудлаар тусгайлан гаргасан хууль тогтоомж, зарим нэгэн онцгой сэдвүүдээр хөгжлийн бэрхшээлийн асуудлыг багтаасан хууль тогтоомж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэхийг онцгойлон дурьдсан заалт бүхий хууль тогтоомжууд хэмээн ангилах боломжтой байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхсан тохиолдлын эсрэг заалт нь хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын хүрээнд тухайлан зааж өгсөн бөгөөд бусад хууль тогтоомжийн хүрээнд хуулийг зөрчсөн гэм буруутанд хариуцлага хүлээлгэх тухай ерөнхийлөн оруулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэдэг тусгайлсан дүрэм, журам байхгүй ч Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд зохицуулагддаг байна.
- Нийгмийн халамжийн сан улсын төсвөөс, Нийгмийн даатгалын сан даатгуулагчдийн шимтгэлээс, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан Ажилгүйдлийн даатгалын шимтгэл, Хөдөлмөрийн хуулийн 111.2 дугаарт заасан төлбөрөөр бүрдүүлдэг байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар хэрэгжүүлсэн болон одоо хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг санхүүжилтийн байдлаар нь улсын төсвөөр, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр, олон улсын байгууллагаас санхүүжүүлсэн хэмээн ангилж болно.
- Монголд Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар үндэсний түвшинд үйлчлэх байнгын ажиллагаатай, хууль ёсны Үндэсний зохицуулах хороо буюу түүнтэй ижил төстэй үүрэг бүхий байгууллага одоогоор байхгүй байна.
- Манайд өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр 70 гаруй төрийн бус байгууллага бүртгүүлсэн байгаагаас оюуны хомсдолтой сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд байхгүй байна.
- 2006 оноос төрийн зохих байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх хуулийн заалтын дагуу ХХҮГазар, НХХЯамтай ХБИБҮХолбоо гэрээ байгуулан ажиллаж зарим ажил үйлчилгээг гүйцэтгэх болжээ.
- Нийгмийн халамжийн тухай хууль /2005/-д зааснаар халамжийн болон асрамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах нь ХХҮГазарт хамаарах бөгөөд төрийн байгууллагуудын хүрээнд хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор ажилтнаа сургалтанд хамруулдаг ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг сургах байдал орхигддог байна.
- Одоогийн байдлаар манайд хэд хэдэн их дээд сургуульд тэр дундаа улсын хэмжээний томоохон сургуулиудад нийгмийн ажилтан бэлтгэж байна. Мэргэшсэн боловсон хүчнээр сургалтыг явуулах, мэргэжилтэн бэлтгэх байдал хангалтгүй байгаа бөгөөд 1990 оноос хойш согогзүйч мэргэжилтэн бэлтгээгүй, монголд ийм мэргэжилтэн бэлтгэдэг сургалт байхгүй, одоогоор ажиллаж байгаа согог зүйчид мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж чаддаггүй байна.

БҮЛЭГ 2.

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2.1 СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Судалгааны үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн салшгүй нэг хэсэг нь хэрэгжилтэд хяналт тавьж, бодитойгоор үнэлэх, улмаар тохирох арга хэмжээг санал болгох, саад бэрхшээл, хүндрэлийг илрүүлэх, стандарт дүрмийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулах хяналт, үнэлгээний механизм юм.

Дүрэмд зааснаар улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш боломжтой холбогдолтой үндэсний хөтөлбөр болон үйлчилгээний хэрэгжилтэд үнэлгээ өгөх, тасралтгүй хяналт тавьж байх үүрэгтэй.

1993 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт өгөх нь олон улсын түвшинд баримталж буй бодлогын хэрэгжилт, Монгол улсын төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, үндэсний хөтөлбөр, төлөвлөлтийн хэрэгжилтийн байдалд анхаарал хандуулан, улам боловсронгуй болгож, үр дүнг сайжруулахад төдийгүй иргэний нийгмийн байгууллагууд тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үүрэг оролцоо, хариуцлагыг өндөрсгөхөд чухал ач холбогдолтой юм.

Судалгааны зорилго

Монголын нөхцөлд өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн бусад гишүүдийн нэгэн адил ижил тэгш эрх үүрэг хүлээх байдлын баталгаажуулалт, хэрэгжилтийн байдлыг тодорхойлох зорилготой бөгөөд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш оролцооны угтвар нөхцөл бүрэлдсэн байдлыг тодорхойлох үнэлэлт, дүгнэлт өгөх
- Тэгш оролцооны зорилтот салбарууд дахь дүрмийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх
- Тэгш оролцооны дүрмийн биелэгдэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх байдлыг тодорхойлох

Судалгааны аргазүй

Судалгааны үед баримталсан үндсэн аргазүй нь

- Баталгаажуулсан байдалд дүн шинжилгээ хийх /бичиг баримтын шинжилгээ, харьцуулсан шинжилгээ/
- Баталгаажуулсан тэгш эрхийн оролцооны дүрмүүдийн бодит байдал дахь хэрэгжилтийн байдалд үнэлэлт өгөх /өмнө нь хийгдсэн судалгааны үр дүн, асуулга, экспертийн асуулга, чанарын мэдээлэл/
- Хэрэгжилтэд холбогдох жишээ, баримтыг бүрдүүлэх, баталгаажуулах

бөгөөд төрийн бодлого, эрх зүйн орчин бүрэлдсэн байдалд түлхүү ач холбогдол өгсөн болно.

Судалгааны ажлын хугацаа богино ажлын материал ихтэй тул нийтлэг үзүүлэлтүүд дэх хэрэгжилтийн байдалд үнэлэлт өгч холбогдох жишээ, баримтыг бүрдүүлж, баталгаажуулсан болно.

2.2 ҮНДСЭН ОЙЛГОЛТЫН ТАЙЛБАР

Хөгжлийн бэрхшээлтэй хүн /тахир дутуу хүн/	Бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамилын болон удамилын бус шалтгаан, төрөлхийн гажиг өөрчлөлт, өвчин, тарилгын дараахь хүндрэл, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон, хараа сонсгол, хэл ярианы болон бие эрхтний тахир дутуу, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суугаа гаададын иргэн, харьяалалгүй хүнийг хэлнэ.
Тэгш боломж	Нийгэм ба орчин тойрны янз бүрийн системүүд юм. Тухайлбал: үйлчилгээ, үйл ажиллагаа, мэдээлэл, бичиг, баримт гэх мэтийн системүүд нийт хүмүүст, тэр дундаа тахир дутуу хүмүүст боломж олгох үйл явц юм.
Тэгш эрхийн зарчим	Хүн болгоны хэрэгцээ нь ижил тэгш чухал гэж үздэг бөгөөд хүн бүр тэгш оролцох боломжтой гэдгийг баталгаажуулах замаар бүх нөөц бололцоонуудыг ашигладаг тэрхүү нийгмийн төлөвлөх зарчим дээр тулгуурлан энэхүү хэрэгцээ бий болох ёстой.
Нийгмийн халамж	Хүн амын эмзэг хэсэгт хамрагдах ахмад настан, эх, хүүхэд, тахир дутуу хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амьжиргааг дээшлүүлэх, түүнчлэн хүүхэд төрүүлсэн эх, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авсан эх /эцэг/ болон ихэр хүүхдэд тэтгэмж олгох агуулга бүхий нийгмийн хамгааллын арга хэмжээг хэлнэ.
Нийгмийн эмзэг хэсэг	Бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие ахмад настан, тахир дууу хүн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд болон нэн ядуу амьдралтай ахмад настан, тахир дутуу хүн, олон хүүхэдтэй эх /эцэг/, нэн ядуу амьдралтай хүнийг хэлнэ.
Нийгмийн асрамжийн үйлчилгээ	Ахмад настан, тахир дутуу хүн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд болон гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг асрамжийн газарт байрлуулан, хоол, хувцас эмнэлэг, соёл, ахуйн үйлчилгээгээр хангах, ерөнхий боловсрол, мэргэжил эзэмшүүлэх хэлбэрээр төрөөс байнга асрамжлах үйлчилгээг хэлнэ.
Нийгмийн халамжийн үйлчилгээ	Иргэнийг түр хугацаагаар хооллох, түүнд наад захын хувцас, хүнс болон ахуй соёлын зарим зүйл олгох, хөнгөлөлт үзүүлэх, мэргэжил эзэмшүүлэх зэрэг төрөөс үзүүлэх үйлчилгээг хэлнэ.
Нийгмийн даатгалын сан	Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.
Тэтгэврийн төрлийг сонгох эрх	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан болзлын дагуу хоёр буюу түүнээс дээш төрлийн тэтгэврийн эрх нэгэн зэрэг үүсч байгаа даатгуулагч тэтгэврийн төрлийг сонгож, тэтгэвэр тогтоолгон авах эрхийг хэлнэ.
Тэтгэвэр	Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл/-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн хэрэгжилт

Тэтгэмж	Хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.
Төлбөр	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 буюу түүнээс дээш хувиар алдсан даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нөхөн олгох хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/-ний үнэ, рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилалын газрын үйлчилгээний хувьсах зардлыг хэлнэ.
Чадвар алдахаас сэргийлэх	Урьдчилан сэргийлэх нийтлэг болон эрүүл мэндийн арга хэмжээ, сэргээн засах цогц арга хэмжээг хэлнэ.
Урьдчилан сэргийлэх нийтлэг арга хэмжээ	Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах болон удамшлын өвчин, эмгэг согог, эмийн хордлого, осол, гэмтэл, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан чадвар алдахаас сэргийлэх нийгмийн арга хэмжээг хэлнэ.
Урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн арга хэмжээ	Төрөхийн өмнөх, төрөх үед болон төрсний дараа хүнд бие эрхтэн, оюун ухаан, сэтгэцийн эмгэг согог үүсэхээс сэргийлэх, эмгэг согог нь үйл ажиллагааны байнгын хязгаарлалт, хөгжлийн бэрхшээлтэй байдалд шилжихээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг хэлнэ.
Сэргээн засах	Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, оюун ухаан, сэтгэцийн чадварыг нөхөн сэргээх замаар нийгмийн амьдралын хэвийн түвшинд хүргэх эрүүл мэндийн, сургалт мэргэжлийн, нийгмийн цогц арга хэмжээг хэлнэ.
Нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгэм, хамт олны хүчинд тулгуурлан тэдний дунд сурах, ажиллах, амьдрах тэгш боломж олгох, нийгмийн харилцаанд оролцох идэвхи, оролцоог нэмэгдүүлэхийг хэлнэ.
Тэгш боломж олгох	Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн бүх төрлийн харилцаанд оролцох боломж нь бусад хүний нэгэн адил байх нөхцөл бүрдүүлэхийг хэлнэ.
Саад бэрхшээлгүй байлгах	Нийтийн тээврийн хэрэгсэл, нийтийн үйлчилгээний барилга байгууламж, мэдээлэл сургалтын хэрэгсэл, ажлын байр зэргийг хөгжлийн бэрхшээлтэй хүн онцгой хүндрэлгүй, бусдын тусламжгүйгээр ашиглах боломжтой байлгахыг хэлнэ.
Байнгын асрамж шаардагдах хүн	Өдөр тутмын үйл ажиллагааг бусдын тусламжгүйгээр бие даан гүйцэтгэх чадваргүй, байнгын асаргаа, сувилгаанд байх хүнийг хэлнэ.

2.3 СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн баг нь хоёр байгууллагын 11 судлаачаас бүрдсэн бөгөөд дараах бүрэлдэхүүнтэйгээр ажилласан болно.

Төслийн удирдагч

Дугарын СҮНЖИД

Хуульч LL.M,
Филантропи хөгжлийн төлөө төвийн
гүйцэтгэх захирал

Төслийн зөвлөх

Рэнчиндоржийн СЭЛЭНГЭ

Социологич МА,
Филантропи хөгжлийн төлөө төвийн тэргүүн

Цэдэнгийн ОЮУНБААТАР

Инженер, техникийн ухааны докторант
МХБИБҮХ-ны ерөнхийлөгч

Төслийн багийн судлаачид

Шагдарсүрэнгийн БЭРЦЭЦЭГ

Социологич МА,
Филантропи хөгжлийн төлөө төвийн
НСМУ-ний албаны дарга, судлаач

Чулуунбаатарын МӨНХЦЭЦЭГ

Хуульч LL.M,
Филантропи хөгжлийн төлөө төвийн
Бизнес мэдээллийн албаны дарга

Базаррагчаагийн БУЯН-ӨЛЗИЙ

Хуульч L.M,
Филантропи хөгжлийн төлөө төвийн
Нийгмийн ажлын албаны ажилтан

Далхаагийн БАТБОЛД

Багш,
МХБИБҮХ-ны гүйцэтгэх захирал,

Гүржавын ЧИНЗОРИГ

МХБИБҮХ-ны удирдах зөвлөлийн гишүүн
Өнөр бүл сангийн тэргүүн

Дамбадондогийн БААТАРЖАВ

Дасгалжуулагч,
МХБИБҮХ-ны удирдах зөвлөлийн гишүүн,
Спортын албаны дарга

2.4 ТӨСЛИЙН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Тус тайлан нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ. Эхний бүлэг буюу үр дүнгийн хураангуй хэсэгт: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгох тэгш боломжийн стандарт дүрмийн танилцуулга, Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлын судлагдсан байдал болон судалгааны үр дүнгийн хураангуйг оруулсан бол Бүлэг 2-т судалгааны ажлын аргазүй, ашиглагдсан ойлголт, нэр томъёоны тайлбар, судлаачдын танилцуулгыг оруулсан ба харин III-Ү бүлгүүдэд үндсэн зорилтын дагуу стандарт дүрмийн хэрэгжилтэд хийсэн судалгааны ажлын үр дүн ба дүгнэлтүүд орсон болно. Бүлэг 6-д Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцооны боломжийн стандарт дүрэмд холбогдох санал ба зөвлөмжийг багтаасан бөгөөд Хавсралт хэсгээс судалгааны ажилд ашигласан албаны болон судалгааны эх сурвалж бүхий бичиг баримтуудын жагсаалт, судалгааны явц, үр дүнд хамаарах баримтжуулсан материалуудыг үзэж болно. Түүнчлэн судалгааны явцад ашиглагдсан товчилсон үг, тайланд орсон хүснэгт болон зургийн жагсаалтыг багтаасан болно.

БҮЛЭГ 3.

**ТЭГШ ОРОЛЦООНЫ УГТВАР
НӨХЦӨЛ БАЙДАЛ**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3.1 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТЭГШ ОРОЛЦООНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛСЭН БАЙДАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцооны тухай стандарт дүрмийг авч үзэхдээ дараах шалгууруудыг үндэс болголоо.

1. Холбогдох хууль болон төрийн бодлого, хөтөлбөрт тусгагдан баталгаажуулсан байдал
2. Үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал
3. Үйл ажиллагааны үр дүнгийн байдал

“Хөгжлийн бэрхшээлтэй хүн” - Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадвар нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ² Өөрөөр хэлбэл чадвар алдагдсан, оролцооны боломж нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэх ажээ. Олон улсад чадвар алдалтын гол шалтгааныг бие эрхтний чадваргүй байдал бус оролцоонд учирч буй орчны саад бэрхшээл³ гэж үзэх болжээ. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хэмээх ойлголтын хүрээнд 1/. Оюун ухаан 2/. Хараа 3/. Сонсгол 4/. Хэл яриа 5/. Тулгуур эрхтэн 6/. Сэтгэц 7/. Хавсарсан хэлбэрийн чадвар алдалтуудыг хамруулдаг байна. Гэтэл манайд хөгжлийн бэрхшээлийн чадвар алдалтад дээрх дурьдсанаас гадна тодруулан хэлбэл халдварт өвчин, сүрьеэ, дотрын өвчнүүдийг багтаан ойлгодог байна.⁴ Олон улсын жишгээс зөрүүтэй ойлголтыг хэрэглэж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай бодитой мэдээлэл цуглуулах, нийгмийн хамгааллын үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд хүндрэл бий болгож байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

1. ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Улс орнууд тахир дутуу хүмүүс, тэдгээрийн эрх, тэдний хэрэгцээ, тэдний чадамж, хувь нэмрийн талаар нийгэмд ойлголтуудыг өгөх үйл ажиллагаа явуулах ёстой.

Монгол Улсын төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой баталсан хууль дүрэмд нийгмийн хандлага, ойлголтыг өөрчлөх, тэгш хамруулах нийгэм сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх тухай зохих хэмжээнд зааж өгсөн байна. Тухайлбал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дугаарт “ажил, амьдралынх нь талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах” арга хэмжээг төрийн зохих байгууллага зохион байгуулна хэмээн зааж өгчээ. Түүнчлэн БСШУЯ, ЭМЯ, НХХЯ-ны сайд нарын хамтарсан 435/302/173 тоот тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр”-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах нийгэм-сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэх, багш, удирдах ажилтанд тусгай сургалт зохион байгуулах, сургууль, гэр бүл, олон нийтэд хандсан мэдээлэл, сургалт явуулах, мэдээлэл, сурталчилгааны хэвлэмэл болон электрон гарын авлага, аудио, видео материалууд, радио, телевизийн нэвтрүүлэг бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулж байгаа боловсролын байгууллага, багш нарыг дэмжих хөдөлгөөн өрнүүлэх тухай тусгагдсан байна.

² Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль 3.1, 2005,

³ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх стратеги 2004 ОУХБ, НҮБ-ын БШУСБ, ДЭМБ

⁴ Эрүүл мэндийн сайдын тушаал 250А жагсаалт

Ердийн өвчин, ахуйн ослийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан даатгуулагчид тэтгэврийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр олгож байна. 2006 оны хоёрдугаар улирлын байдлаар 50.1 мянган хүний тахир дутуугийн тэтгэвэрт 10.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Улсын Нийгмийн Даатгалын Газар www.ndaatgal.mn

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх зөв ойлголт, хандлагыг бий болгоход анхаарах, үнэн бодитой мэдээллийг хүргэх талаар үр дүн бүхий үйл ажиллагаа цөөхөн зохион байгуулагдаж ирсэн бөгөөд 2000 оноос харьцангуй илүү анхаарч 2001 оноос “Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл”, 2003 оноос МХБИБҮХолбооны дэргэдэх “Хүмүүн заяа” сонин зэрэг нь энэ талын мэдээллийг олон нийтэд хүргэх болжээ.

Өнөөгийн байдлаар Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай мэдээлэл цөөнгүй явагдаж байгаа бөгөөд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан сургалт явуулах, гарын авлага гаргах, өдөр тутмын сонингуудтай хамтран мэдээллийн булан ажиллуулах зэрэг төсөлт үйл ажиллагаануудыг НХХЯ, ОУХБ, ХЭҮК, МХБИБҮХ гэсэн байгууллагуудаас хэрэгжүүлсэн байна. Тухайлбал: МУ-ын ЗГ, АХБ-ны шугамаар Японы Ядуурлыг бууруулах сангаас санхүүжигдэн хэрэгжсэн “Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” төсөл нь хэрэгжих хугацаандаа /2002-2005/ 648 мэдээ, сурвалжлага, ярилцлага, өгүүлэл нийтэлж, телевизийн 28, радиогийн 30 нэвтрүүлэг цацаж, “Тэргэнцэртэй хүний түүх” сэдэвт цуврал радио зохиомжийг Монголын Үндэсний радиогоор явуулжээ.

МХБ-р урьтгаж байна

Өдөр тутмын сонинд хэвлэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой мэдээллийг агуулгаар нь авч үзэхэд мэдээллийн 25 гаруй хувь нь төр болон олон улсын байгууллага, олон нийтийн хөдөлгөөнөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан хийж, бүтээж буй ажил, үйлчилгээний талаар дурьдсан байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагын мэдээлэл- 15, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асуудал дэвшүүлсэн хийгээд шүүмжилсэн нийтлэл-15, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил, амьдралын тухай-20, мөн сурталчилгааны болон хандив, тусламж хүссэн мэдээллүүд үлдэх хувийг эзэлж байна.⁵

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр тодорхой хэмжээнд явагдаж байгаа ч мэдээллийн агуулгад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэр хүнд хийгээд эрхэд шууд болон шууд бусаар халдсан, үл хүндэтгэсэн, бүдүүлэг үг хэллэг ашигласан гэх зэрэг байдлууд ч мөн цөөнгүй байгаа нь тэдний талаарх сөрөг хандлагыг бий болгох, нийгмийн хүлээн авалтад сөргөөр нөлөөлөх боломжтой байгаа юм.

Хэдийгээр энэ талын мэдээллийн хүртээмж нэмэгдсэн гэж болох ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн ойлголт хандлагад үр дүнтэй нөлөөлөл үзүүлж чадахгүй байна.

1999 онд ЭМНХЯ-ны захиалгаар МУИС-ийн Социологийн тэнхимээс явуулсан “Тахир дутуу иргэдийн нийгмийн хэрэгцээ”, 2005 онд Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн асуулгын судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүр байдлыг тодорхойлов.

1999 онд хэрэгжүүлсэн судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 71,4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүсээс ялгаатай “өөр хүмүүс” гэж үзэж байжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтийн дунд “нийгмийн эмзэг” хэмээх бүлгийн өвчин, эмгэгтэй /23,8%/, нийгмийн зүгээс анхаарал, халамж байнга шаарддаг /45,5%/, хүмүүс гэсэн ойлголт одоо ч хэвээр байна. Иргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай зохих мэдээлэлтэй байдаг /81,2%/, гэж хариулж байсан ч үнэн зөв мэдээлэл авч чаддаггүй, байнга харилцаад байдаггүй /20,6%/, тул тэдэнтэй сайнаар харьцаж чаддаггүй гэжээ.

*83,8
1925*

Судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь /52,8%/, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс авдаг бөгөөд 14,7 хувь нь тэдний талаарх мэдээллийг авч чаддаггүй, харин 3,1 хувь нь мэдээлэл авахыг ч хүсдэггүй байна.

Судалгааны дүнгээс харахад иргэдийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой эрх зүйн мэдлэг хангалтгүй байгаа бөгөөд тэр дундаа энэ хуулиар эрх ашгаа хамгаалуулдаг иргэд

⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн хэрэгжилтийн байдал” судалгааны төслийн хүрээнд хийгдсэн хэвлэлийн контент анализын дүнгээс

хамгийн тааруу мэдлэгтэй байдаг ажээ. Тодруулан хэлбэл судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 45 орчим хувь нь өөрсдийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийг ямар нэг хэмжээгээр мэддэг бол тэдний гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдын 48 орчим хувь, энэ чиглэлээр ажил, үйлчилгээ эрхэлдэг хоёр хүн тутмын нэг нь дээрх хууль, тогтоомж, тушаал тэргүүтнийг тодорхой түвшинд мэддэг байна.

Судалгаанд хамрагдсан энгийн иргэдийн 36.5 хувь нь л энэ талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй гэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн бүрийн 2 нь, тэдний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагчдын талаас бага хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашигтай холбоотой мэдээллийг цаг тухайд нь авч чаддаггүй байна.

Эндээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай олон нийтийн ойлголт төсөөлөлд сүүлийн 6 жилд ахицтай өөрчлөлт гараагүй байна гэж хэлэх боломжтой байна.

Монгол Улсын төрөөс олон улсын хийгээд олон нийтийн байгууллагуудтай хамтарсан тодорхой төсөл хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай нийгэмд зөв ойлголт, хандлага төлөвшүүлэх талаар арга хэмжээг цөөнгүй хэрэгжүүлж байгаа хэдий ч олон нийтийн дунд төдийлөн эерэг нөлөөлөл үзүүлж чадахгүй байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, энэ чиглэлээр ажил үйлчилгээ эрхэлдэг ажилтнуудад ч мэдээлэл хангалтгүй бөгөөд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ойлголтын түвшин ч мөн хангалтгүй байна.

3.2 ҮР ДҮНТЭЙ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий
Ассамблей Тогтоол 48/96

2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

Улс орнууд тахир дутуу
хүмүүсийг үр дүнтэй
эмнэлгийн тусламжаар
хангахыг
баталгаажуулах ёстой.

Монгол улсад 1993 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбогдсон харьцангуй цөөн тооны хөтөлбөр батлагдан, хэрэгжсэн байна.

Нийгмийн эрүүл мэндэд хандсан хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх бодлого, үйл ажиллагааны үндэсийг Эрүүл мэндийн тухай хууль /1998.05.07/-д зааж өгсөн бөгөөд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль /2000.04.20/, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль /2002.04.25/, Нийгмийн халамжийн тухай хууль /2005.12.01/-иар зохицуулж байна. Үндэсний хэмжээнд “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр” /2002.04.03/, “Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр” /2002.07.16/-үүдийг хэрэгжүүлж байна. 2006 оны 11 дүгээр сард “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг баталжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг илрүүлэх ажлыг зохион байгуулахад анхааран ЭМЯ, Италийн Засгийн газрын бус

АИФО байгууллагаас хамтран хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах Тэгш дүүрэн хөтөлбөр”-ийн хүрээнд 2006 оны 04 сарын 03-ны өдрийн тушаалаар “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг илрүүлэх” судалгааны болон тайлангийн маягтыг баталсан.

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар суурь харилцааг хуульчлан тогтоож өгсөн ч үндэсний хэмжээнд төлөвлөн хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн нэр төрөл, тоо хэмжээ нь нийгмийн хэрэгцээг хангалттай түвшинд хангаж чадахгүй байна.

Стандарт дүрмийн энэ хэсэгт хамаарах зайлшгүй нэг асуудал бол бүх эмч, эмнэлгийн тусламж өгөх талаар нэгэн адил сургалтад хамрагдаж, тоног төхөөрөмжөөр хангагдах, мөн холбогдох

эмчилгээний арга, технологийг хүртэх үйл ажиллагааг баталгаажуулсан байх явдал юм. Эмч мэргэжилтэн бэлтгэх сургалтын ерөнхий хөтөлбөрт энэ нь тодорхой хэмжээнд тусгагдсан байдаг бөгөөд хэрэгжиж буй хөтөлбөрийн хүрээнд мөн хөндөгддөг байна. Тухайлбал: “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”-т ерөнхий мэргэжлийн болон нарийн мэргэжлийн боловсон хүчнийг сургах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг орчин үеийн жишигт нийцүүлэх, оношлогоо, эмчилгээний орчин үеийн тоног, төхөөрөмж багаж хэрэгслээр хангах тал дээр анхааран ажиллаж байгаа бол “Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр”-т өндөр мэргэжлийн боловсон хүчнийг давтан сургахын сацуу нийгэм, хамт олны бүлгүүдэд эмнэлгийн анхан шатны тусламжийн үйлчилгээ үзүүлэх мэдлэг, дадлага эзэмшүүлэхэд анхаарчээ.

Холбогдох хууль болон төрийн бодлого, хөтөлбөрт энэ тухай тусгаж өгсөн бөгөөд төлөөлөл оролцуулах, санал авах байдал тодорхой хэмжээнд байдаг ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хийгээд тэднийг төлөөлөн оролцож буй байгууллагуудын санал, зөвлөмж тусгагдах байдал хангалтгүй байна.⁶

Хэдийгээр хууль эрх зүйн орчин зохих түвшинд батлагдсан ч хэрэгжилтийн түвшиндээ тэр бүр хангалттай байж чаддаггүй байна. Үүнийг мөн дээрх судалгааны үр дүнгээс харах боломжтой юм.

Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн таван хүн тутмын хоёр нь, тэдний асран хамгаалагчид, гэр бүлийн гишүүдийн гурван хүн тутмын нэг нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой ажил үйлчилгээ эрхлэгчдийн гурван хүн тутмын хоёр нь л хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авч чаддаг гэжээ.⁷

Төрийн хууль тогтоомж, бодлогын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үр дүнтэй эмнэлгийн тусламжаар хангах асуудал тодорхой түвшинд хөндөгдөн орсон ч хэрэгжүүлэлтийн хэмжээнд цөөн хэдэн нэр төрөл, чиглэлийн хөтөлбөрөөр хязгаарлагдаж байгаа төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрт энэ үйлчилгээ жигд хүрч чадахгүй байна.

3.3 СЭРГЭЭН ЗАСАЛТ⁸-ЫН ҮЙЛЧИЛГЭЭ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

3. СЭРГЭЭН ЗАСАЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үйл ажиллагааны болон бие даасан бусдын хамааралгүй байх хамгийн боломжит дээд түвшинд хүргэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сэргээн засалтын үйлчилгээгээр хангагдахыг Улс орнууд баталгаажуулах ёстой.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”-д /2005.12.01/ “хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, чийрэгжих, өөрөө өөртөө үйлчилж сурах, хөдөлмөрлөх чадвартай болох зорилгоор үйл ажиллагаа нь алдагдсан эрхтнээ сэргээх, солиулах зэргээр засах эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах эрхтэй” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сэргээн засалттай холбоотой үндсэн эрхийг зааж өгсөн бөгөөд Засгийн газрын 118 тоот тогтоол /2006.05.24/-оор баталсан “Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх журам, НХХЯ-ны сайдын 55 тоот тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хөтөлбөр”, 2006 оны 11 дүгээр сард “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-өөр баталгаажуулж өгчээ.

Эрүүл мэндийн тухай хууль /1998.05.07/-д “сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн болон удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах зарим эмгэгийн эмчилгээ . . .” –г Монгол улсын

⁶ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн хэрэгжилтийн байдал” судалгааны төслийн хүрээнд хийгдсэн ХБИБ-уудын төлөөлөлтэй хийсэн бүлгийн ярилцлагын дүнгээс

⁷ 2005 онд Италийн Засгийн газрын бус АИФО байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн асуулгын судалгааны үр дүн УБ., 2005

⁸ “Сэргээн засалт гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие бялдрын, мэдрэхүйн, оюун санааны, сэтгэцийн ба нийгмийн үйлдлүүдийн түвшингийн өөрийнх нь дээд хэмжээнд хүргэхийн тулд тэдгээрийн амьдралыг биеэ даах хамгийн дээд түвшинд хүргэхэд хэрэглүүр болгож чадваржуулах үйл явц юм. Сэргээн засалтад үйл ажиллагааг дахин сэргээх ба хангах, алдагдсан үйл ажиллагаа, үйлдлийн хязгаарлагдмал байдлыг нөхөх, орлуулах арга хэмжээнүүдийг хамруулна.

иргэнд түүний эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үлд хамааран эмнэлгийн тусламж үйлчилгээг төлбөргүй үзүүлнэ.

Үндэсний хэмжээнд “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр” /2002.04.03/ -ийн хүрээнд нийгэм, хамт олонд тулгуурласан сэтгэцийн нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулах аргачлал боловсруулах, сэтгэцийн өвчтэй хүмүүст үзүүлэх сэтгэцийн нөхөн сэргээх тусламжийн зохих арга хэмжээг авах чиглэлээр тодорхой үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлжээ.

ЭМЯ, Италийн Засгийн газрын бус АИФО байгууллагаас хамтран хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах Тэгш дүүрэн хөтөлбөр”⁹-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, эмч, эрүүл мэндийн дунд мэргэжилтэн, багш, сайн дурынхныг сургалтанд хамруулжээ.

1998-2000 онд 11 аймаг, Улаанбаатар хотын 6 дүүрэгт үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна. Эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үл хамааран эмнэлгийн дараах тусламж, үйлчилгээг төлбөргүй үзүүлнэ хэмээн зааж, сэргээн засах төрлийн зарим эмчилгээ, үйлчилгээг үнэ төлбөргүй хүртэх эрхийг баталгаажуулж өгсөн байна.

Монгол улсад 10 асрамжийн газар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд багагүй хамрагддаг байна. Түүнчлэн сувиллын үйлчилгээгээр өглөлт, өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, эмчийн зөвлөгөө, нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдах зэргээр үйлчлүүлдэг бол нийгмийн халамжийн үйлчилгээ эхлэл төдий хэмжээнд байдаг ажээ. Монголд одоогоор ажиллаж байгаа сувиллын газрууд жилд дундажаар 400-450 хүнд нөхөн сэргээх, сувилах үйлчилгээг үзүүлдэг.

Сэргээн засалтын Үндэсний Төв нь 2005 онд болон 2006 оны эхний хагаст 833 өвчтөн хүлээн авч 8230 ор хоног ашиглан хэвтүүлж, амбулаториор 1225 хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлсэн байна.

2005 онд Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн асуулгын судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 45.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байдалд шилжихээс өмнөх урьдчилан сэргийлэх үзлэгт, 47.1 хувь нь бие эрхтний ажиллагааг нөхөн сэргээх эмчилгээнд, 51.4 хувь нь алдагдсан ажиллагааны хязгаарлалтыг нөхөн сэргээх эмчилгээнд, 33.1 хувь нь эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээнд огт хамрагдаж байгаагүй ажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засалтын үйлчилгээгээр хангах тухай үндсэн харилцаа нь хууль эрх зүйн хийгээд төрийн бодлогын түвшинд баталгаажсан гэж болох ч энэ чиглэлээр хөгжлийн бэрхшээлийн бүх хэлбэрийг багтаасан үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн байдал нь учир дутагдалтай байна. Сэргээн засалт шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүс энэхүү үйлчилгээг хүртэж чадахгүй байна.

⁹ 1992-1996 онд Нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах хөтөлбөрийн бэлтгэл шат, 1997-2001 он ЕХолбооны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн. 1999 оноос “Тэгш дүүрэн” хөтөлбөр болсон.

3.4 ТУСЛАХ ХЭРЭГСЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ
СТАНДАРТ ДҮРЭМ**

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

4. ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өдөр тутмын амьдралд бие дааж оролцох түвшинг дээшлүүлэхэд нь мөн өөрсдийнхөө эрхийг эдлэхэд нь туслахын тулд туслах хэрэгсэл зэрэг туслах үйлчилгээгээр хангах, хөгжүүлэхийг Улс орнууд баталгаажуулах ёстой

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан туслах хэрэгсэл, туслах үйлчилгээгээр хангах асуудлыг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль” /2005.12.01/, “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль” /1994.06.07/, “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль” /2002.04.25/, “Боловсролын тухай хууль” /2002.05.03/, Бага дунд боловсролын тухай хууль” /2002.05.03/, Дээд боловсролын тухай хууль” /2002.05.03/ гэсэн хуулиудад заан өгч зохих журам, дүрмээр баталгаажуулж өгсөн байна.

Тухайлбал: Монгол улсад хэрэгжиж буй хуулийн дагуу Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 10 гаруй төрлийн хөнгөлөлт үзүүлдэг бөгөөд¹⁰ эдгээрээс 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг хоёр удаа

100 хувь нөхөн олгох, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг эхний удаа 100 хувь, хоёр дахь удаа 50 хувь нөхөн олгох, ядуу амьдралтай өрхийн 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй, ядуу амьдралтай өрхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг нэг удаа нөхөн олгох зэргийг дурьдаж болно.

Сэргээн засалтын Үндэсний Төв нь 2005 онд болон 2006 оны эхний хагаст 1561 хүнд үйлчилж 70773.3 сая төгрөгийн протез, ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэсний 16223.1 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас, 18637.6 сая төгрөгийг иргэд өөрсдөө төлж, 1138.7 мянган төгрөгийг буяны болон албан байгууллагын хандив тусламжаар үйлдвэрлэсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн туслах хэрэгслийг Олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хүргэж байгаа ч нэр төрөл, тоо хэмжээний хувьд тэр бүр хангалттай байж чадахгүй байна. Орон нутгийн нийгмийн халамжийн газруудаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай байгаа тэргэнцэрийн тоо хэмжээг тогтоон Хөдөлмөр, Нийгмийн халамжийн Газарт захиалдаг байдлаар ханган нийлүүдэг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд нийгмийн халамжийн газраас нийлүүдэг тэргэнцэрийн чанар хангалтгүй байдаг гэсэн гомдол их байгаа бөгөөд асуудал хариуцсан албан тушаалтнууд төсөвлөгдсөн мөнгөнд багтаан өмнөд хөршөөс хямдханыг оруулж ирдэг тул чанартайг нийлүүлж чаддаггүй гэж байв.

2006 оны 11 дүгээр сард баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие эрхтний согог засах, протез, ортопедийн хэрэгслийн хангамжийг сайжруулахад анхааран багагүй үйл ажиллагааг төлөвлөжээ. Тухайлбал: хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчих зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд гаргах, хараагүй иргэдэд зориулсан “ярьдаг болон брайл номын сан”-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, тоног төхөөрөмжөөр хангах зэрэг болно.

¹⁰ Ч.Дагвадорж, Нийгмийн хамгаалал: онол-арга зүй, туршлага, харьцуулалт 2004 он

БҮЛЭГ 4.**ЗОРИЛТОТ САЛБАРУУД ДАХЬ ТЭГШ
ОРОЛЦООНЫ БАЙДАЛ****UIH.MN**
СУДАЛГААНЫ САН

4.1 БИЕ БЯЛДРЫН ХИЙГЭЭД МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ОРЧНЫ ХҮРТЭЭМЖ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

5. ХҮРТЭЭМЖ

Улс орнууд нийгмийн бүх давхаргад тэгш боломжийн явц нь бүх талаараа хүртээмжтэй байхын чухлыг таньж мэдэх ёстой. Ямар ч хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд Улс орнууд (а) Бие бялдрын /хөдөлгөөний/ орчинг хүртээмжтэй байлгах хөтөлбөрүүдийг танилцуулах, (б) мэдээлэл, харилцаа холбоог хүртээмжтэй болгох арга хэмжээнүүдийг авах ёстой.

Зорчих орчны хязгаарлалт бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэн дэд бүтэц, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, байгуулах, засах, тохижуулах асуудалд Монголын улсын төр, засгийн газраас анхааран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль” /2005.12.01/ “Барилгын тухай хууль” /1998/, “Авто замын тухай хууль”-иудад /1998/ ерөнхий байдлаар зааж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт /2004-11-05/ тусгаж өгчээ. 2006 оны 11 дүгээр сард баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т энэ асуудалд анхаарал хандуулжээ.

Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын даргын 2004.03.04 тоот тушаалаар “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” /БД 31-101-04/ -ийг баталсан бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын нэг бүрчилсэн зураг төсөл зохиох, барилгыг шинээр барих, барьсан барилгуудад хэсэгчилсэн болон иж бүрэн шинэчлэл өргөтгөл хийх, ашиглалтад хүлээн авах, ашиглахад зориулагдсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, харилцаа холбоог хүртээмжтэй болгох хууль эрх зүйн асуудлыг боловсронгуй болгоход цаашид анхаарах хэрэгтэй байгаа нь холбогдох хууль тогтоомжид хангалттай тусгагдаагүй буюу хэт ерөнхий

байдлаар тусгасан байгаагаас харж болох юм.

“Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” /БД 31-101-04/ -ийг мөн оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд НЗДТГазраас 2006 оны байдлаар шинээр баригдсан бүх авто зам, гүүрийн даалгаварт тусгасан байна. ЗТАЖЯамнаас энэ онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам барих, “хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон дугуйтай хүн, явган зорчигчдын зориулалтын зам”-ын Үндэсний стандартыг батлах, түүнийг сурталчлах, мөрдөх ажлыг зохион байгуулахад анхааран ажиллаж байгаа төдийгүй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих зориулалтын тоноглол бүхий тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлэх” зорилгоор судалгааны ажлыг эхлүүлэх байдлаар энэ чиглэлийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, харилцаа холбоог хүртээмжтэй болгох тал дээр Монголд үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаа чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал: Хүүхдийг ивээх сан /Английн/, АДРА олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд тэр дундаа Монголын дүлий иргэдийн “Дэмжих гар” холбооноос олны хүртээл болгосон хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүүхэд залуучууд, тэдний гэр бүлийн гишүүд болон эхлэн суралцагчдад зориулсан дохионы хэлний ном болон гарын авлага тэргүүтнийг дурьдаж болох юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан хүргэж байгаа ч энэ нь хүн бүрт хүрэх боломж, нөхцөл бага байгаа бөгөөд өдөр тутмын мэдээ мэдээллийг дохионы хэлний орчуулгатай хүргэх асуудал бүрэн шийдвэрлэгдэж, тогтмолжоогүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай хэрэгцээт боловсролын байгууллагууд сургалтын үйл ажиллагаандаа дохионы хэл, хараагүй хүүхдэд зориулсан брайл хэвлэгч болон бусад туслах хэрэгслүүдийг цөөн тоогоор боловч ашигладаг нь зохих үр дүнгээ өгч байна.

4.2 БОЛОВСРОЛЫГ ИНТЕГРАЦЧИЛСАН ТҮВШИНД ЭЗЭМШИХ БАЙДАЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

6. БОЛОВСРОЛ

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуус, насанд хүрсэн хүмүүсийн анхдагч, хоёрдогч, гуравдагч боловсролыг интеграцчилсан түвшинд эзэмших боломжийн зарчмыг таньж илрүүлэх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол нь боловсролын системийн салшгүй нэгэн хэсэг гэдгийг Улс орнууд баталгаажуулах ёстой.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль” /2005.12.01/ -ийн 7.1-д “Сүрьеэ зэрэг архаг халдвартай өвчний архаг халдварын үед байгаагаас бусад тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл иргэдтэй хамт сурч, боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй” хэмээн заажээ.

1995 онд батлагдсан “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрөөр сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамруулах, холбогдох судалгааг аймаг, сум, нийслэл, дүүргээр нарийвчлан гаргаж, боловсрол олгох сургалт, хүмүүжлийн ажилд хөнгөлөлттэйгээр хамруулах, боловсролын агуулга, арга хэлбэрийг туршин тогтоох” 2001 оноос хэрэгжсэн “Сургуулийн өмнөх боловсрол-2” үндэсний хөтөлбөрөөр тусгай хэрэгцээтэй бага насны хүүдийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад үе шаттайгаар хамруулан, тэдний сурах хэрэгцээг хангахад чиглэсэн орчинг түлхүү анхаарчээ.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөр”-ийг 2003 оны 12 дугаар 25-ны өдөр Монгол Улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухаан, Эрүүл Мэнд, Нийгмийн

Хамгаалал Хөдөлмөрийн сайдын хамтарсан 435/3002/173 тушаалаар баталгаажуулан хэрэгжүүлж эхэлжээ. ДАНИДА болон ХИС /Англи/, БСШУЯ-ны санаачлага дэмжлэгтэйгээр 2008 он хүртэл хэрэгжих энэ хөтөлбөрийн хүрээнд ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах, боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлэх, боловсролын тусгай хэрэгцээг хангах үйлчилгээг боловсронгуй болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах нийгэм-сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудалд НҮБ-ын Хүүхдийн сан, ТАСИС, ХИС /Англи/, АДРА, Дэлхийн зөн, Данида, АИФО зэрэг олон улсын байгууллагуудын үүрэг оролцоог үнэлэх нь зүйтэй.

Өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагддаг тусгай цэцэрлэг 3¹¹, сургууль 5¹², сургалт үйлдвэрлэлийн төв 1¹³ нийслэл хотод ажиллаж байна. Ерөнхий боловсрол олгодог тусгай сургуулиудаас 4 нь оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгоход түлхүү анхааран ажилладаг боловч стандарт дүрэмд заасны дагуу хамгийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдийг бүрэн хамруулж чадахгүй байна. ҮСГ-аас гаргасан статистик судалгааны дүнгээс харахад 7, түүнээс дээш настай нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 15,0 хувь нь бичиг үсгийн боловсролгүй байгаа бөгөөд 15-24 насныхны дунд энэ үзүүлэлт нь илүү өндөр байна.¹⁴ Түүнчлэн 7-29 насны нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 16 хувь нь л боловсрол олгох сургуульд суралцдаг аж. Тэдний 36 хувийг харааны, 53 хувийг сонсох эрхтний бэрхшээлтэй хүмүүс эзэлж байна.

2004-2005 онд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 816 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдсаны 386 нь оюун ухааны хөгжлөөр дутмаг, 430 нь бусад эрхтний согогтой хүүхэд байлаа. 2005-2006 оны хичээлийн жилд нийт хөгжлийн бэрхшээлтэй 839 хүүхэд хамрагдсан байна.

нийт 839 хүүхэд нь хамрагдсан

¹¹ 8, 10, 76 дугаар цэцэрлэг

¹² 29, 116 дугаар сургуулиуд нэгдэн Хараагүй, дүлий хүүхдийн цогцолбор сургууль болсон, 55, 25, 63, 70 дугаар сургуулиуд ажиллаж байна.

¹³ Мэргэжлийн Сургалт Сэргээн Засалтын Үндэсний төв

¹⁴ Үндсэн үр дүн: Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл, түүвэр судалгаа 2004 он ҮСГ, АХБ

Манай улсын сургуульд сураагүй 3-7 насны 236.3 мянган хүүхдээс 79.0 мянга нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, хамрагдалтын хувь 33.4 хувь болж байна. Эдгээр хамрагдсан хүүхдийн 0.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй гэж бүртгэгджээ. СӨБ-д хамрагдахгүй байгаа хүүхдүүдийн дотор эзлэх ядуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх мэдээлэл дутмаг байгаа нь тэднийг эрт оношлох, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээнд хамруулахад хүндрэл учирч байна.

Манай улсын 8-17 насны хүн амд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эзлэх хувь 7.1% байна. Сургуулийн гадна байгаа суурь боловсрол эзэмших насны хүүхдийн 11.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эзэлж байна. /Хүн амын статистик мэдээ. 2000, БСШУЯ-ны статистик мэдээ 2002, 2003/

Сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиолдож буй бэрхшээлээс үзэхэд тэдний 46.1 хувь нь хичээлээ бүрэн ойлгодоггүй, 46.6 хувь нь бусад хүүхдүүд шоолж дээрэлхдэг гэж хариулсан байна.¹⁵

Ерөнхий боловсролын эрх бүхий байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн интеграцчилсан боловсролыг хариуцан ажиллаж байгаа бөгөөд олон улсын байгууллагуудын дэмжлэг оролцоо их юм. Гэсэн ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэр дундаа хүүхэд бүр боловсрол эзэмшиж чадахгүй байгаа төдийгүй интеграцчилсан сургалт явуулж буй сургалтын байгууллагуудад хүртээмж, туслах үйлчилгээнүүд хүрэлцэхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн сургалттай сургуульд суралцахад нийгмийн хүлээн авалт болон тухайн хүүхдийн сэтгэл зүйн бэлтгэл мөн хангалтгүй байна.

4.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

7. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Улс орнууд хөдөлмөр эрхлэлтийн салбарт эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүч чадал өгөх зарчмыг таньж мэдэх ёстой. Хот болон хөдөөд тэд хөдөлмөрийн захаас ажил олох, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ижил тэгш боломжтой байх ёстой.

Монгол улс Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Тахир дутуу хүмүүсийн эрхийн тухай тунхаглал, Хөдөлмөр эрхлэлтэнд алагчлахгүй байх тухай конвенц /1969/, Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай ОУХБ-ын 159 дүгээр конвенцийг /1998/ соёрхон баталж, нэгдэн орсон бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль /1992/, Хөдөлмөрийн тухай хууль /1999/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль /2005/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2001/, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль /1998/ гэсэн эрх зүйн актуудын хүрээнд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлын суурь харилцааг зохицуулж өгчээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар /2006 оны нэмэлт өөрчлөлт/ тусгайлан баталгаажуулж өгсөн бөгөөд эдгээр хуульд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авах, ажиллуулаагүй тохиолдолд төлөх төлбөр хийгээд түүний зарцуулалт, ажлын цаг, хөдөлмөрийн нөхцлийн хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх хөнгөлөлт, мэргэжлийн сургалтаар мэргэжил эзэмшүүлэх тухай асуудлыг шийдвэрлэх боломжийг олгожээ. Түүнчлэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам” /2002/, Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг /2006/ батлан хэрэгжүүлж байна.

Монгол улсад 2005 онд ажил идэвхтэй хайж бүртгүүлсэн ажилгүй 32.9 мянган хүн байгаагийн 0.4 мянга буюу 1.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй болон одой иргэд эзэлж байна. Нийт бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8.1 хувь нь дээд, 7.4 хувь нь тусгай дунд, 29.9 хувь

¹⁵ Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал судалгааны тайлан 2006 он

нь бүрэн бус дунд, 7.4 хувь нь бага, 6.3 хувь нь огт боловсролгүй хүмүүс байв. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар энэ онд 555 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын, 125 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг түр ажлын байраар хангажээ.¹⁶ 11 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1.0-10.0 сая хүртэлх төгрөгийн зээл олгон, 25 ажлын байрыг шинээр бий болгон ажиллахад дэмжлэг үзүүлжээ. Түүнчлэн мэргэжил олгох сургалтад 479 иргэнийг хамруулсан байна. 2005 онд 230.5 сая төгрөгийг “Тахир дутуу буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай данс”-нд төвлөрүүлснээс 98.7 хувийг нь Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу тахир дутуу буюу одой хүнийг тодорхой хувьд заасан хэмжээгээр ажиллуулаагүй аж ахуйн нэгж байгууллагуудаас орж иржээ.

ОУХБ болон бусад ОУБ-ын дэмжлэгтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг бүхий нийгмийн орчинг буй болгоход анхааран ирсэн байна. Тухайлбал: Монгол Улсын ЗГ, АХБ-ны шугамаар Японы Ядуурлыг бууруулах сангаас санхүүжигдэн “Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл” 2002 оноос хэрэгжсэн бөгөөд төслийн хүрээнд 2004 он гэхэд 1677 хүнийг ажлын байранд зуучилж, 825 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 40 гаруй мэргэжлээр сургаж, 35 сургалтын байгууллагад санхүүгийн дэмжлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 136 аж ахуйн нэгж, бүлэг хүмүүст 62,360 ам.долларын, хувиараа бизнес эрхлэгч 140 хүнд 33,820 ам.долларын дэмжлэг үзүүлжээ. ОУХБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг эрх зүйн хүрээнд дэмжих нь” төслийг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөх багийг НХХСайдын 2006 оны 44 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулж, төслийн хүрээнд 2006-2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг зөвлөх багийн хуралдаанаар хэлэлцүүлж, саналыг тусгажээ.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй гурван иргэний нэг нь огт ажил хөдөлмөр эрхэлдэггүй гэж хариулсан ч ердөө 15.0% ажил хөдөлмөр эрхлэхэд хүндрэл, бэрхшээлтэй байдалтай огт тулгардаггүй гэжээ. Харин асран хамгаалагчдын дөрөвний нэг нь, албан хаагчдын ердөө 5.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хөдөлмөр эрхлэх байдлаар нийгмийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцоход хүндрэл гардаггүй гэж хариулсан байна. Судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд бусдынхаа дундаас өөрийгөө дөвийлгөн үнэлэх байдал ажиглагдаж байгаа нь өөрсдийнх нь хэрэгцээ шаардлагатай холбоотой юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийн нөхцөл боломж, чадварыг илүү үнэлж байгаа бөгөөд ажил хөдөлмөр эрхлэх чадвартай гэж 40 гаруй хувь нь үзсэн ч тэдний гэр бүлийн гишүүд асран хамгаалагчид бараг хоёр дахин доогуур үнэлжээ. Албан хаагчдын үнэлгээ асран хамгаалагчдынхаас илүү өндөр байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийгөө үнэлж байгаа байдлаас харьцангуй бага байгаа юм.¹⁷ Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрөөс бодлого, хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэхэд анхаарч байгаа ч хөдөлмөр эрхлэх боломжтой олон хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Энэ нь дээрх үйл ажиллагаанууд нь өргөн цар хүрээг хамарч чадахгүй байгаатай холбоотой нөгөө талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх сэтгэл хийгээд бие бялдрын хувьд бэлтгэх, нийгмийн хүлээн авалт, үнэлэмжийн асуудал багагүй нөлөөлж байгаа билээ.

4.4 ОРЛОГО ОЛОХ БОЛОН НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20

НҮБ-ын Ерөнхий Ассамблей Тогтоол 48/96

8. ОРЛОГО ОЛОХ БОЛОН НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг орлого олох болох нийгмийн хамгааллаар хангах хариуцлагатай.

Монгол Улсын Үндсэн хууль /1992/, Хөдөлмөрийн тухай хууль /1999/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль /2005/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2001/, Нийгмийн даатгалын тухай хууль /1994/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хууль /1994/, Нийгмийн халамжийн тухай хууль

¹⁶ Хөдөлмөрийн зах зээлийн 2005 оны жилийн эцсийн тайлан НХХЯ. 2006 он

¹⁷ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь УБ., 2005

/2005/, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль /1998/, Тахир дутуу иргэдэд ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх тухай Засгийн газрын тогтоол /1995/ гэсэн эрх зүйн актуудын хүрээнд иргэдийн орлого, олох нийгмийн хамгааллын асуудлын суурь харилцааг зохицуулж өгчээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалал, орлогын байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2006 оны нэмэлт өөрчлөлт/, Нийгмийн даатгалын тухай зэрэг хуулиудаар тусгайлан баталгаажуулж өгсөн бөгөөд эдгээр хуульд зааснаар монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийг зохих орлоготой байхыг баталгаажуулсан төдийгүй нийгмийн хамгааллын чиглэлийн төрийн бодлогод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зөвхөн халамжийн тэтгэвэр аваад суухаас илүүгээр ажил хөдөлмөр эрхлэхэд нийгэм, хамт олны дунд идэвхтэй амьдрах, өөрсдийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг дэмжихэд анхаарсан бодлого хэрэгжүүлж үүнийгээ ч зохих хууль, тогтоомжийн хүрээнд баталгаажуулжээ. Хэдийгээр энэ нь зарим талаар хэтийн ирээдүйтэй бодлого гэж болох ч өнөөдрийн нөхцөл байр сууринд хэрэгжихэд түвэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашиг зөрчигдөх боломжтой бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд илүү ихээр анхаарах хэрэгтэй байна. Түүнчлэн зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бус тэднийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжийг Нийгмийн халамжийн тухай хуульд тусгаж өгчээ.

Монголын нийгмийн хамгааллын тогтолцоо нь нийгмийн даатгал, нийгмийн халамж гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд даатгалын харилцаа сайтар төлөвшөөгүй тул нийгмийн халамжийн үйлчилгээ харьцангуй их байр суурийг эзэлдэг байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэгсдийн дунд харьцангуй тогтвортой бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд юм. Хуульд заагдсаны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдахдаа дараах болзлыг хангадаг байна.

- Хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан
- Бүрэн хараагүй, хэлгүй, дүлий болон одой хүн
- Хүний амь аврах, гоц аюулт халдварт өвчний голомтод ажиллах буюу байгалийн гамшиг, осолтой тэмцэж иргэний журамт үүргээ биелүүлж яваад хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуу болсон хүн

Энэ нь тухайн нийгэмд гүйцэтгэсэн үүрэг, эрхэлж байсан ажил, албан тушаалаас хамааралгүйгээр амьжиргааны доод түвшинг хангахад олгож байгаа учраас хэмжээ нь бусад тэтгэврээс бага байдаг. Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдээ асарсанаас ажил хийх боломжгүй асран хамгаалагчид тэтгэмж олгогдог ба хөгжлийн бэрхшээлтэй бусад хүүхдэд ямар нэгэн хөнгөлөлт, тэтгэмж, тэтгэвэр тусгагдаагүй. Түүнчлэн 70 хувьд хүрээгүй гэсэн шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй олон иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж чадахгүй байна.

Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд 10 гаруй төрлийн хөнгөлөлт үзүүлдэг бөгөөд энэ хөнгөлөлт нь тэдний амьдрал ахуйд бага ч гэсэн дэмжлэг, тусалцаа болдог байна.¹⁸ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд заасны дагуу орон сууцны хөлс, түлээ нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 50000 төгрөгөөр, ядуу амьдралтай, хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй, насанд хүрсэн бүрэн хараагүй иргэнтэй өрхийн суурин телефон утасны төлбөрт сар бүр үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээг 10000 төгрөгөөр тус тус тогтоож, 2006 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдүүлэхээр боллоо.¹⁹ Нийгмийн халамжийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор “Амьжиргаанд туслах халамжийн хөтөлбөр”, “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн хөтөлбөр”, “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хөтөлбөр”-ийг эцэслэн боловсруулж НХХСайдын 2006 оны 55 дугаар тушаалаар батлуулжээ.

Нийгмийн халамжийн сангаас 2005 онд нийтдээ 42.2 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээний хэлбэрээр 955.6 мянган хүнд олгосон бол энэ оны эхний 4 сарын байдлаар 770.0 мянган хүнд 15.2 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

¹⁸ Ч.Дагвадорж, Нийгмийн хамгаалал: онол-арга зүй, туршлага, хурьцуулалт 2004 он

¹⁹ Засгийн газрын 2006 оны 133 дугаар тогтоолоор шийдвэрлүүлэв.

Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан даатгуулагчид тэтгэврийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр олгодог бөгөөд 2006 оны 2 дугаар улирлын байдлаар 50,1 мянган хүнд 10.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Сүүлийн 5 жилд 6.0 мянга орчим даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ хийлгэх, рашаан сувилалд эмчлүүлэхэд зориулж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 440.7 сая төгрөг зарцуулжээ.²⁰

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг тэтгэврийн насанд хүртэл нь, сувилах сувиллын газрын сувилахад ногдох хийгээд сувилалд ирэх, буцах унаа, хиймэл эрхтэн, засал эмчилгээний тодорхой нөхцөлт зардлуудыг Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлдөг байна.²¹

2006 оноос арилжааны хэд хэдэн банкаар²² дамжуулан нийгмийн эмзэг хэсэгт ажлын байр бий болгох зээл олгох болсон нь сайшаалтай ч банкны бодлого, нийгмийн бодлоготой уялдуулах байдалд анхаарах хэрэгцээтэй байна.

Хэдийгээр төрийн бодлого, үйл ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын асуудалд анхааран зохих төсөв хөрөнгө зарцуулсаар байгаа ч бодит байдал дээр энэ нь зайлшгүй хүмүүстээ хүрч чадахгүй байсаар байна.

2004 онд гаргасан ҮСГ-ийн бүртгэл, түүвэр судалгаагаар Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1.6 хувь нь буюу 8000 гаруй иргэн эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор тахир дутуугаа тогтоолгоогүй байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын тогтоолыг үндэслэн тахир дутуу хүнийг сум, дүүргийн Засаг даргын тамгын газар бүртгэж, тахир дутуугийн үнэмлэх олгох бөгөөд үнэмлэх нь түүний хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болдог байна. Тэгвэл дээрх 8000 гаруй хүн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй байна.

Түүнчлэн энэхүү судалгаанд хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 22.6 хувь нь л нийгмийн халамжийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлдэг хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагддаг гэсэн бөгөөд үлдсэн 77.4 хувь нь буюу 2057 иргэн энд хамрагдаж чаддаггүй гэжээ.

2005 онд Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд хийгдсэн судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцсон таван хүн тутмын хоёр нь нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй байна.

²⁰ <http://www.ndaatgal.mn>

²¹ Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль 2004

²² ХАС банк, Капитал банк, ХААН банк

4.5 ХУВИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДАЛ: ГЭР БҮЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей Тогтоол
48/96

9. ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛ БОЛОН ХУВИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүлийнхээ амьдралд бүрэн оролцохыг дэмжих ёстой. Тэдний хувийн эрх чөлөөтэй байх эрхийг дэмжиж, хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бэлгийн харилцаа, гэрлэлт болон эцэг эхийн холбооны ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхахгүй байхыг баталгаажуулах ёстой.

Монгол Улсын Үндсэн хууль /1992/, Иргэний хууль /2002/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль /2005/, Нийгмийн халамжийн тухай хууль /2005/, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль /1998/, Гэр бүлийн тухай хууль /1999/, Хувь хүний нууцын тухай хууль /1995/ гэсэн хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн эрх болон гэр бүл, гэрлэлтийн асуудалд хамаарах суурь харилцааг зохицуулж өгчээ. Монгол УИХ, ЗГ-аас Гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг 2003 онд батлан хэрэгжүүлжээ. Монгол улсад хэрэгжиж буй хууль тогтоомжуудын хүрээнд гэрлэгчид бие биеэ, эцэг эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг эхээ, төрөл, садангийн хүмүүс бие биеэ энэ хуульд заасны дагуу тэжээн тэтгэх үүрэгтэй бөгөөд хөдөлмөрийн чадваргүй хүүхэд нь насанд хүрсэн хойно ч эцэг эхийн энэхүү үүрэг нь хүчинтэй байдаг ажээ. Түүнчлэн гэрлэгчдийн хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулах болон гэрлэлт хүчин төгөлдөр бус болсонд тооцогдохоос өмнө, эсхүл гэрлэлтээ цуцлуулснаас

хойш нэг жилийн дотор хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан нь гэр бүлийн хүчирхийлэл болон гэрлэлт цуцлуулахаас өмнө бий болсон нөхцөл байдалтай шууд холбоотой үүссэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй бол салсан нөхөр буюу эхнэрээрээ тэжээн тэтгүүлэх эрхтэй төдийгүй гэрлэлт цуцлах үед хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа тохиролцож болдог байна. Эрүүл мэндийн байдлын улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй хүнийг гэр бүл, хүүхэд, ач зээ болон төрөл садангийн хүмүүс нь харгалзан дэмжих, харгалзан дэмжигч тогтоогдоогүй бол асрамжийн газарт болон холбогдох газарт шилжүүлэх ажээ. Монгол улсын эрүүгийн хууль /2002/-д эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ шунахай зорилгоор урвуулан ашигласан, асран хамгаалж байгаа хүнээ хараа хяналтгүй байлгасан, шаардлагатай тусламж үзүүлэлгүй орхисон бол торгох, түр хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулдаг байна. Эндээс хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүлтэй байж, тэжээн тэтгүүлэх, харгалзан дэмжүүлэх байдал эрх зүйн хүрээнд баталгаажсан нь харагдаж байна. Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асран хамгаалагчдыг дэмжих, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгохыг заасан байдаг. Гэр бүлийн тухай хуульд гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол гэрлэхийг хориглодог бөгөөд сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрхийн бүрэн чадамжгүй гэж тогтоогдсон хүнийг асран хамгаалалтад байлгах, сэтгэцийн өвчтэй хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглосон байна. Хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжийн хүрээнд удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй л биш бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд хувь хүний эрхийн дагуу гэрлэх, гэр бүлийн амьдрал зохиох эрхтэй ажээ.

Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг Хувь хүний нууцын тухай хууль /1995/-иар хамгаалсан байдаг. Хувь хүний нууцад эрүүл мэндийн нууц багтдаг бөгөөд тухайн хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг нууцалдаг байна.

2004 онд НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр НХХЯамны захиалгаар Гал голомт хөдөлгөөний судлаачдын багийн гүйцэтгэсэн “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, цаашдын хандлага” судалгааны дүнгээс үзэхэд өнөөгийн байдлаар хүүхдээ насанд хүртэл тэжээн тэтгэж, хөдөлмөрийн чадваргүй бол насанд хүрсэн хойно нь тэжээн тэтгэх үүргийг эрэгтэйчүүдийн 61.8 хувь нь, эмэгтэйчүүдийн 57.0 хувь нь сайн биелүүлж байгаа гэж үзсэн бол хүүхэд насанд хүрээд эргээд эцэг эхээ тэжээн тэтгэж байгаа байдал сайн байгаа гэж нийт хүмүүсийн тал хүрэхгүй (47.0) хувь нь сайшаан үнэлжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэр дундаа оюуны хомсдолтой хүүхдийн бэлгийн бойжилттой уялдуулсан бэлгийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн мэдээлэл, сургалтын ажил орхигдож байгаа төдийгүй насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бэлгийн хэвийн харилцаанаас хөндийрч үүнээс үүдэлтэй сэтгэцийн хямрал, өөрчлөлт бий болох байдал ч цөөнгүй байдаг байна.²³

тодруулах

4.6 СОЁЛ, СПОРТ БА ЧӨЛӨӨТ ЦАГАА ӨНГӨРӨӨХ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

10. СОЁЛ

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг соёлын үйл ажиллагаануудад ижил тэгш оролцуулах, интеграцчилах, ажлыг баталгаажуулах ёстой.

Монгол Улсын Үндсэн хууль /1992/-иар Монгол Улсын иргэн нь соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй бөгөөд зохиогчийн шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаалдаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын хуулийн 9 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг олон улсын болон өөрийн оронд зохиогддог соёл, урлаг биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцоход нь төрөөс дэмжих бөгөөд соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээ нь түүний чадавхид зохицсон байна гэж заажээ. Түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид эдгээр иргэдийн соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд санхүүгийн туслалцаа үзүүлэх арга хэмжээг төрийн зохих байгууллага зохион байгуулна гэсэн байна.

ЗГ-ийн 2001 оны 187-р тогтоолоор Пара олимп, дэлхийн дүлий иргэдийн спортын тоглолтыг олимпийн наадамд оролцдоггүй спортын төрлийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнтэй адилтган үзэж шагнал, уламшуулал олгохоор заасан байна. Түүнчлэн Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн оюутан элсүүлэх журамд хөгжлийн бэрхшээлтэй спортын авъяастай иргэдийг шууд элсүүлэхээр заасан зэргээс дүгнэхэд энэхүү стандарт нь зохих байдлаар хэрэгжиж байгаа бөгөөд харин хүртээмжийн хувьд жигд бус байна. 2005 онд хэрэгжсэн төслийн асуулгын судалгааны үед шинээр боловсруулах хуулинд оруулах зайлшгүй өөрчлөлтөд олимп, тив дэлхийн аварга шалгаруулах тэсцэнд өндөр амжилт үзүүлсэн тамирчдыг эрүүл тамирчдынхтай адил шагнал, урамшуулал олгох тухай заалтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 72.9 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүлийн гишүүн, асран хамгаалагчдын 62,5 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой ажил, үйлчилгээ эрхэлдэг албан хаагчдын 78,3 хувь нь дэмжиж санал өгсөн байна.²⁴ 2005 онд ЭМЯамны сайдын тушаалаар Биеийн Тамир Спортын Улсын Хороонд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамир спортын асуудал хариуцсан мэргэжилтэн бий болгожээ.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

11. СПОРТ БА ЧӨЛӨӨТ ЦАГАА ӨНГӨРӨӨХ

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чөлөөт цаг болон спортоор хичээллэх ижил тэгш боломжтой гэдгийг баталгаажуулах арга хэмжээнүүдийг авах ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох, хөгжих боломжийг үнэлсэн байдал

	ХБИ өөрөө	ХБИ бусдынхаа тухай	Асран хамгаалагч	Албан хаагч
авъяас чадварыг нээн хөгжүүлэх боломж	29.5	10.8	26.9	42.9
мэдлэг авъяас чадварыг бусдад таниулан сурталчлах	16.3	8.3	25.1	34.8
мэдлэг, авъяас чадвар, амжилтыг үнэлүүлэх, шагнал, урамшил авах	8.3	5.5	20	28.5

²³ Экспертийн судалгаа- Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш оролцооны стандарт дүрмийн хэрэгжилт судалгааны дүн 2006

²⁴ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь УБ., 2005

4.7 ШАШИН ШҮТЛЭГ

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ
СТАНДАРТ ДҮРЭМ**

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей Тогтоол
48/96

12. ШАШИН ШҮТЛЭГ

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөлөөт цаг болон спортоор хичээллэх ижил тэгш боломжтой гэдгийг баталгаажуулах арга хэмжээнүүдийг авах ёстой.

Монгол Улсын Үндсэн хууль /1992/-иар Монгол Улсын иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажуулсан бөгөөд Онц болон дайны байдал зарласан тохиолдолд ч хүний амьд явах эрхийн адилаар итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хязгаарлахыг хориглосон байна. Түүнчлэн Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль /1993/-д аливаа шашныг шүтэх, эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг бөгөөд шүтэхийг албадах, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглох уг хүн өөрөө хүссэнээс бусад тохиолдолд албан баримт бичигт тусгахыг хоригложээ. Монгол Улсын Эрүүгийн хууль /2002/-д хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийг зөрчих, шүтэж байгаа шашинаар нь хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгих, шашины харгис үзэл номлол сурталчлах, тараахыг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэн

зохих шийтгэл оноохыг заажээ.

Тэнд очихоор идэх юм, бас саван, сальфетика зэрэг өгдөг гэхээр нь очдог болсон. Одоо байнга очиж байгаа . . .

Х.А -22 настай ХБИ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь Монгол улсын иргэнийхээ хувьд дээрх үндсэн эрх, эрх чөлөөг бүрэн эдэлнэ.

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шашин шүтэх эрх нь чөлөөтэй ч эдийн засгийн боломжгүй байдлаасаа шалтгаалан зарим шашин, шашины урсгалд өөрийн хүслээр бус эдийн засгийн сонирхлоор татагдан орох байдал мэр сэр байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

БҮЛЭГ 5.

АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5.1 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ БА СУДАЛГАА

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

13. МЭДЭЭЛЭЛ БА СУДАЛГАА

Улс ориууд хамгийн дээд боломжит аргаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын нөхцөл байдлын талаарх мэдээллийг цуглуулах, түгээх хариуцлагыг хүлээх ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд нөлөөлж буй саад бэрхшээл бүрийн талаар иж бүрэн судалгаа хийх ажлыг дэмжинэ.

Монгол улсад өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар явуулсан томоохон цар хүрээ бүхий судалгаануудыг

1. Төрийн үйлчилгээний байгууллагын албаны
2. Улс үндэстний хэмжээнд хийгдсэн мэргэжлийн
3. Төрийн бус байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн тодорхой асуудалт

хэмээн ерөнхийд нь ангилан үзэх боломжтой юм.

Дээр дурьдсан ангилал бүхий судалгаанууд нь тооны хувьд харьцангуй цөөн төдийгүй үр дүнгийн хувьд ч харилцан адилгүй байдаг байна. Тухайлбал: Манай улсын нийт хүн амын 5 орчим хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг гэсэн тоо баримт байдаг ч албаны эр сурвалжаас гаралтай зарим тоо баримтууд зөрөх байдал их байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар бодитой судалгаа хийхэд нэр томъёо, ойлголтын байдлыг нэн тэргүүнд цэгцлэх, олон улсын жишигт хүргэх нь чухал байна.

2004 онд явуулсан ҮСГ-ын бүртгэл, түүвэр судалгаагаар нийт хүн амын 2.8 хувийг /69263/ хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг байна.

Италийн засгийн газрын бус АИФО байгууллагаас явуулсан судалгааны дүнгээс дурьдахад манай улсад нийт

хүн амын 4.8 хувь буюу 115 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа бөгөөд тэдний 65 хувь нь эмэгтэйчүүд бол 34000 хүүхэд байдаг гэжээ.

Төрийн үйлчилгээний байгууллагын судалгаа нь тухайн байгууллага, салбарын үйлчилгээг хүртэгсдийн мэдээлэлд үндэслэсэн байдаг бол бусад нь түүвэр судалгааны мэдээлэлд тулгуурласан байна. Судалгааны аргазүй, “хөгжлийн бэрхшээл”-ийг тодорхойлсон байдал хийгээд цар хүрээ нь дээрх судалгаануудын дүнг зөрүүтэй гарахад нөлөөлжээ.

Дээр дурьдсан судалгаануудаас гадна НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн зөн олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны хийж гүйцэтгэсэн “Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” 2006 он, 1999 онд ЭМНХЯ+ны захиалгаар МУИС-ийн Социологийн тэнхимийн гүйцэтгэсэн “Тахир дутуу иргэдийн нийгмийн хэрэгцээ”, “МЭ Консалтинг” ХХК-ийн “Хөдөлмөрийн зах зээлд тахир дутуу иргэдийн оролцоо” зэрэг судалгаануудыг нэрлэж болно.

Өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлын талаар нэгдсэн мэдээллийн сан байхгүй бөгөөд төрийн үйлчилгээний байгууллагын тайлан мэдээ, салбарын бодлого, хөтөлбөр, хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын тухай мэдээллийг холбогдох байгууллагын мэдээллийн сангаас тодорхой хэмжээгээр авах боломжтой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой нэр томъёо хийгээд үндэсний судалгаа, хяналт, үнэлгээнд ашиглагдах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох хэрэгцээ байгаа бөгөөд энэ асуудалд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын саналыг авах, хамтран боловсронгуй болгох хэрэгтэй юм.

5.2 БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ТӨЛӨВЛӨХ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

14. БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ТӨЛӨВЛӨХ

Улс орнууд бүхий л төрлийн
холбогдох бодлого гаргах
болон үндэсний түвшинд
төлөвлөлт хийхэд хөгжлийн
бэрхшээлийн асуудлууд орж
байхыг баталгаажуулах
ёстой.

Үндэсний түвшинд төлөвлөж хэрэгжүүлж буй төрийн бодлогуудад болон ерөнхий хөгжлийн төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлийн асуудлыг оруулж өгдөг бөгөөд орон нутгийн түвшинд үйл ажиллагааг дэмжихэд зохих байдлаар анхаардаг байна.

Боловсролын салбарт баримталж буй бодлого:

Сүрьеэ зэрэг архаг халдвартай өвчний архаг халдварын үед байгаагаас бусад тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл иргэдтэй хамт сурч, боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй²⁵ бөгөөд сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамруулах, холбогдох судалгааг аймаг, сум, нийслэл, дүүргээр нарийвчлан гаргах боловсрол олгох сургалт, хүмүүжлийн ажилд хөнгөлөлттэйгээр хамруулах, боловсролын агуулга, арга хэлбэрийг туршин тогтоох²⁶, тусгай хэрэгцээтэй бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын сургалтад үе шаттайгаар хамруулан, тэдний сурах хэрэгцээг хангахад чиглэсэн орчинг бүрдүүлэхэд²⁷,

түлхүү анхаарчээ.

Ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах, боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлэх, боловсролын тусгай хэрэгцээг хангах үйлчилгээг боловсронгуй болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах нийгэм-сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэхэд²⁸ анхааран ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарт баримталж буй бодлого:

Монгол улсад 1993 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбогдсон харьцангуй цөөн тооны хөтөлбөр батлагдан, хэрэгжсэн байна. Нийгмийн эрүүл мэндэд хандсан хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх бодлого, үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг илрүүлэх ажлыг зохион байгуулах²⁹, эмч мэргэжилтэн бэлтгэх сургалтын ерөнхий хөтөлбөрт тусгах, нийгэм, хамт олны бүлгүүдэд эмнэлгийн анхан шатны тусламжийн үйлчилгээ үзүүлэх мэдлэг, дадлага эзэмшүүлэхэд анхаарч байна.

Нийгмийн хамгааллын салбарт баримталж буй бодлого:

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийг зохих орлоготой байхыг баталгаажуулж өгсөн төдийгүй нийгмийн хамгааллын чиглэлийн төрийн бодлогод хөгжлийг бэрхшээлтэй иргэдийг зөвхөн халамжийн тэтгэвэр аваад суухаас илүүгээр ажил хөдөлмөр эрхлэхэд, нийгэм, хамт олны дунд идэвхтэй амьдрах, өөрсдийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг дэмжихэд анхаарсан бодлого хэрэгжүүлж³⁰ үүнийгээ ч зохих хууль, тогтоомжийн хүрээнд баталгаажуулжээ. Түүнчлэн зөвхөн

²⁵ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль” /2005.12.01/-ийн 7.1-д

²⁶ 1995 онд батлагдсан “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөр

²⁷ 2001 оноос хэрэгжсэн “Сургуулийн өмнөх боловсрол-2” үндэсний хөтөлбөр

²⁸ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөр”-ийг 2003 оны 12 дугаар 25-ны өдөр Монгол Улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухаан, Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн сайдын хамтарсан 435/3002/173 тушаалаар баталгаажуулан хэрэгжүүлж эхэлжээ. ДАНИДА болон Хүүхдийг ивээх сан /Англи/, БСШУЯ-ны санаачлага дэмжлэгтэйгээр 2008 он хүртэл хэрэгжинэ

²⁹ Эрүүл мэндийн тухай хууль /1998.05.07/-д зааж өгсөн бөгөөд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль /2000.04.20/, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль /2002.04.25/, Нийгмийн халамжийн тухай хууль /2005.12.01/-иар зохицуулж байна. Үндэсний хэмжээнд “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр” /2002.04.03/, “Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр” /2002.07.16/

³⁰ Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2006 оны нэмэлт өөрчлөлт/, Нийгмийн даатгалын тухай хууль зэрэг хуулиудаар тусгайлан баталгаажуулж өгсөн

хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бус тэднийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжийг Нийгмийн халамжийн тухай хуульд тусгаж өгчээ.

Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 10 гаруй төрлийн хөнгөлөлт үзүүлдэг бөгөөд Нийгмийн халамжийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор “Амьжиргаанд туслах халамжийн хөтөлбөр”, “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн хөтөлбөр”, “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хөтөлбөр”-ийг эцэслэн боловсруулж, батлуулжээ³¹.

Хөдөлмөр эрхлэлтийн салбарт баримталж буй бодлого:

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авах, ажиллуулаагүй тохиолдолд төлөх төлбөр хийгээд түүний зарцуулалт, ажлын цаг, хөдөлмөрийн нөхцлийн хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх хөнгөлөлт, мэргэжлийн сургалтаар мэргэжил эзэмшүүлэх тухай асуудлыг шийдвэрлэх боломжийг олгожээ³². Түүнчлэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам” /2002/, Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг /2006/ батлан хэрэгжүүлж байна.

Дэд бүтцийн салбарт баримталж буй бодлого:

Зорчих орчны хязгаарлалт бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэн дэд бүтэц, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, байгуулах, засах, тохижуулах асуудалд Монголын улсын төр, засгийн газраас анхааран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын нэг бүрчилсэн зураг төсөл зохиох, барилгыг шинээр барих, барьсан барилгуудад хэсэгчилсэн болон иж бүрэн шинэчлэл өргөтгөл хийх, ашиглалтад хүлээн авах, ашиглахад зориулагдсан байна³³. “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” /БД 31-101-04/ -ийг мөн оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд НЗДТГазраас 2006 оны байдлаар шинээр баригдсан бүх авто зам, гүүрийн даалгаварт тусгасан байна. ЗТАЖЯамнаас энэ онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам барих, “хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон дугуйтай хүн, явган зорчигчдын зориулалтын зам”-ын Үндэсний стандартыг батлах, түүнийг сурталчлах, мөрдөх ажлыг зохион байгуулахад анхааран ажиллаж байгаа төдийгүй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих зориулалтын тоноглол бүхий тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлэх” зорилгоор судалгааны ажлыг эхлүүлэх байдлаар энэ чиглэлийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байна.

Мэдээлэл харилцааны салбарт баримталж буй бодлого

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, харилцаа холбоог хүртээмжтэй болгох хууль эрх зүйн асуудлыг боловсронгуй болгоход цаашид анхаарах хэрэгтэй байгаа нь холбогдох хууль тогтоомжид хангалттай тусгагдаагүй буюу хэт ерөнхий байдлаар тусгасан байгаагаас харж болох юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан хүргэж байгаа ч энэ нь хүн бүрт хүрэх боломж, нөхцөл бага байгаа бөгөөд өдөр тутмын мэдээ мэдээллийг дохионы хэлний орчуулгатай хүргэх асуудал бүрэн шийдвэрлэгдэж, тогтмолжоогүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай хэрэгцээт боловсролын байгууллагууд сургалтын үйл ажиллагаандаа дохионы хэл, хараагүй хүүхдэд зориулсан брайл хэвлэгч болон бусад туслах хэрэгслүүдийг цөөн тоогоор боловч ашигладаг нь зохих үр дүнгээ өгч байна.

³¹ НХХ-ийн сайдын 2006 оны 55 дугаар тушаал

³² Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар /2006 оны нэмэлт өөрчлөлт/ тусгайлан баталгаажуулж өгсөн

³³ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль” /2005.12.01/ “Барилгын тухай хууль” /1998/, “Авто замын тухай хууль” –иудад /1998/ ерөнхий байдлаар зааж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт /2004-11-05/ тусгаж өгчээ. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын даргын 2004.03.04 тоот тушаалаар “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” /БД 31-101-04/ -ийг баталсан

Бизнесийн салбарт болон татварын салбарт баримталж буй бодлого:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн³⁴ орлогыг хүн амын орлогын албан татвараас чөлөөлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн³⁵ ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагсдад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж буй хувь хэмжээгээр тооцон албан татварын хөнгөлөлт үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардагдах тоног, төхөөрөмж, түүхий эдийг гаалийн албан татвараас чөлөөлөх³⁶, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэлийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх³⁷, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагад хөнгөлөлт үзүүлэх зэргийг бодлого, үйл ажиллагааны хүрээнд баталгаажуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх болон тэдний эдийн засгийн болон нийгмийн статуст нөлөөлдөг хөтөлбөрүүд, төлөвлөгөөнүүдтэй холбоотой шийдвэр гаргах түвшинд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг хамруулах байдал төдийлөн хангалттай бус³⁸ байгаа тул цаашид анхаарах хэрэгтэй юм.

5.3 ХУУЛЬ ТОГТООМЖ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

15. ХУУЛЬ ТОГТООМЖ

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн оролцоо, тэгш боломжийн зорилгодоо хүрэхийн тулд хууль зүйн үндсийг бүрдүүлэх үүрэгтэй.

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно хэмээн Монгол Улсын Үндсэн хууль /1992/-д заасан бөгөөд хөдөлмөрийн чадвар алдах тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхийг баталгаажуулж өгчээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамаарах хууль тогтоомжуудыг дараах байдлаар бүлэглэн үзэх боломжтой юм.

1. Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар тусгайлан гаргасан хууль тогтоомж:
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль-2005
 - Тахир дутуу иргэдэд ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх тухай Засгийн газрын тогтоол 2005
 - “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний аж байдлыг

- сайжруулах хөтөлбөр”-ийг батлах тухай ЗГ-ын тогтоол 2006 оны 11 дугаар 22-ны өдөр
- “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” /БД 31-101-04 Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын даргын 2004.03.04 тоот тушаал
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөр”-ийг 2003 оны 12 дугаар 25-ны өдөр Монгол Улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухаан, Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн сайдын хамтарсан 435/3002/173 тушаал
- “Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх журам бөгөөд Засгийн газрын 118 тоот тогтоол /2006.05.24/
2. Зарим нэгэн онцгой сэдвүүдээр хөгжлийн бэрхшээлийн асуудлыг багтаасан хууль тогтоомж:
 - Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль 1994
 - Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль 1994
 - Нийгмийн халамжийн тухай хууль 2005
 - Нийгмийн даатгалын тухай хууль 1994

³⁴ Хараагүй, дүлий болон тулах эрхтний гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувь алдсан тахир дутуу хүн-ХАОАТ-ын хууль 1992 он

³⁵ 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан-Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хууль 1992 он

³⁶ Гаалийн тарифийн тухай хууль 1996 он

³⁷ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 1998 он

³⁸ Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш оролцооны олон улсын стандарт дүрмийн хэрэгжилт: ХБИБ-уудын төлөөлөлтэй хийсэн бүлгийн ярилцлагын үр дүнд “төлөөлүүлэн оролцох хүний тоо хангалтгүй, санал авдаг ч тусгах нь хангалтгүй” гэсэн нэгдсэн дүгнэлтийг хийсэн.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэхийг онцгойлон дурьдсан заалт бүхий хууль тогтоомж:

- Хөдөлмөрийн тухай хууль /1999/
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2001/
- ХАОАТ-ын хууль 1992 он
- Эрүүл мэндийн тухай хууль /1998.05.07/
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль /2000.04.20/
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль /2002.04.25/
- Хувь хүний нууцын тухай хууль /1995/
- Монгол улсын эрүүгийн хууль/2002/
- Иргэний хууль /2002/
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль /1998/
- Гэр бүлийн тухай хууль /1999
- Боловсролын тухай хууль /2002.05.03/
- Бага дунд боловсролын тухай хууль /2002.05.03/
- Дээд боловсролын тухай хууль /2002.05.03
- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль /2005/

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхсан тохиолдлын эсрэг заалт нь хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын хүрээнд³⁹ тухайлан зааж өгсөн бөгөөд бусад хууль тогтоомжийн хүрээнд хуулийг зөрчсөн гэм буруутанд хариуцлага хүлээлгэх тухай ерөнхийлөн оруулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэдэг тусгайлсан дүрэм, журам байхгүй ч Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд зохицуулагддаг байна.

5.4 ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

16.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох үндэсний хөтөлбөрүүд болон арга хэмжээнүүдийн хувьд санхүүгийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн⁴⁰ орлогыг хүн амын орлогын албан татвараас чөлөөлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн⁴¹ ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагсад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж буй хувь хэмжээгээр тооцон албан татварын хөнгөлөлт үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардагдах тоног, төхөөрөмж, түүхий эдийг гаалийн албан татвараас чөлөөлөх⁴², хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зориулалтыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх⁴³, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагад хөнгөлөлт үзүүлэх зэргийг бодлого, үйл ажиллагааны хүрээнд баталгаажуулсан байна.

Нийгмийн халамжийн сан улсын төсвөөс, Нийгмийн даатгалын сан даатгуулагчдын шимтгэлээс, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих⁴⁴ сан Ажилгүйдлийн даатгалын шимтгэл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих⁴⁵-өөр бүрдүүлдэг байна. 2005 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 280 сая төгрөгийн санхүүжилт төвлөрсөн байна. Нийгмийн

³⁹ Хөдөлмөрийн тухай хууль 1999

⁴⁰ Хараагүй, дүлий болон тулах эрхтний гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувь алдсан тахир дутуу хүн-ХАОАТ-ын хууль 1992 он

⁴¹ 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан-ААНБОАТ-ын хууль 1992 он

⁴² Гаалийн тарифийн тухай хууль 1996 он

⁴³ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 1998 он

⁴⁴ ХХҮГ-ын дэргэдэх

⁴⁵ 111.2 Аж ахуйн нэгж байгууллага энэ хуулийн 111.1 дүгээр заасан хэмжээнд тахир дутуу буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө. 111.4 энэ хуулийн 111.2-т заасан

халамжийн үйлчилгээнд зориулан 2006 онд 42 тэрбум төгрөгийг төрөөс зарцуулсан бөгөөд 2007 онд 75 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар хэрэгжүүлсэн болон одоо хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг санхүүжилтийн байдлаар нь улсын төсвөөр, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр, олон улсын байгууллагаас санхүүжүүлсэн хэмээн ангилж болно. Тухайлбал: “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”, “Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрүүд улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, санхүүгийн бусад эх үүсвэрээс бүрдэн санхүүжигдсэн бол 2001 оноос хэрэгжсэн “Сургуулийн өмнөх боловсрол-2” үндэсний хөтөлбөр нь улсын төсөв, гадаад орон олон улсын байгууллага⁴⁶, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хандив тусламжаар санхүүжигджээ. Түүнчлэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах Тэгш дүүрэн хөтөлбөр”-ийг Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна.

5.5 АЖЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

17. АЖЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

Улс орнууд хөгжлийн бэрхшээлийн асуудлаар үндэсний түвшинд үйлчлэх Үндэсний зохицуулах хороо эсвэл ижил төстэй үүрэг бүхий байгууллагыг бий болгох, бэхжүүлэх үүрэгтэй.

Монголд Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар үндэсний түвшинд үйлчлэх байнгын ажиллагаатай, хууль ёсны Үндэсний зохицуулах хороо буюу түүнтэй ижил төстэй үүрэг бүхий байгууллага одоогоор байхгүй байна.

1992 онд Ази, Номхон далайн орнуудын тахир дутуу хүмүүсийн 10 жилийн ажлын хүрээнд Үндэсний хороо байгуулагдсан хэдий ч 1994 оны ЗГ-ын 66 тоот тогтоолоор татан буугдсан байна.

2004 онд НХХЯ-ны дэргэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан салбар хороо байгуулагдсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудаас 3 хүний төлөөлөл оржээ. Харамсалтай нь энэ салбар хороо өнөөг хүртэл дорвитой үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй байна.

2006 оны 11 дүгээр сард батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хороог Монгол улсын Ерөнхий сайдаар удирдуулахаар баталжээ. Уг хорооны бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудаас зохих төлөөллийг оруулсан байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэн уг хөрөнгийг тахир дутуу буюу одой хүнд зориулах нийгмийн хамгааллын арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

⁴⁶ Хүүхдийг ивээх сан- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөр”-ийг 2003 оны 12 дугаар 25-ны өдөр Монгол Улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухаан, Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн сайдын хамтарсан 435/3002/173 тушаалаар баталгаажуулан хэрэгжүүлж эхэлжээ.

5.6 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БАЙГУУЛЛАГУУД

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

18. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БАЙГУУЛЛАГУУД

Улс орнууд үндэсний, бүсийн болон орон нутгийн түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төлөөлөх байгууллагуудын эрхийг таньж мэдэх ёстой. Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар шийдвэр гаргах түвшинд ХБИБ-уудыг зөвлөх үүрэгтэйгээр хамруулж байх ёстой.

Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрхийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй⁴⁷.

Манайд өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр 70⁴⁸ гаруй төрийн бус байгууллага бүртгүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудад зориулсан төрийн эдийн засгийн бодлого, дэмжлэг байхгүй. 2006 оноос төрийн зохих байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх хуулийн заалтын⁴⁹ дагуу ХХҮГазар⁵⁰, НХХЯамтай ХБИБҮХолбоо⁵¹ гэрээ байгуулан ажиллаж зарим ажил үйлчилгээг гүйцэтгэх болжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд төрийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар болон ХБИБҮХолбооны ерөнхийлөгч нь НХХЯамны сайдын

зөвлөлд бодлого боловсруулалтын асуудал хариуцан ажилладаг, 2005 оны 7 дугаар сард тус холбоо Бивакогийн мянганы хөтөлбөрийг хэрэгжүүлэх гишүүн байгууллага болсон зэрэг нааштай алхамууд хийгдэж байгаа ч стандарт дүрэмд заагдсан зөвлөх үүргээ хангалттай биелүүлж чадахгүй байна⁵².

Түүнчлэн Оюуны хомсдолтой сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд байхгүй байна.

ХБИУХолбоо нь өөрийн гишүүн байгууллагуудыг чадавхижуулах, тэдгээрийн хүний нөөцийн асуудалд болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах асуудалд түлхүү анхаарч байгаа бөгөөд тэр дундаа орон нутгийн салбар нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлогыг баримталж байна.

5.7 ХҮНИЙ НӨӨЦИЙН СУРГАЛТ

Нийгмийн халамжийн тухай хууль /2005/-д зааснаар халамжийн болон асрамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах нь ХХҮГ-т хамаарах бөгөөд төрийн байгууллагуудын хүрээнд хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор ажилтнаа сургалтанд хамруулдаг ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг сургах байдал орхигддог байна. Түүнчлэн төрийн үйлчилгээний байгууллагын асуудал хариуцсан ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах аргазүй олгох хичээл сургалт явагдаггүй ажээ.

⁴⁷ Төрийн бус байгууллагын тухай хууль 1997

⁴⁸ Албан бус эх сурвалж 2003 оны байдлаар 53 төрийн бус байгууллага бүртгүүлсэн-ХЗДХЯамны мэдээ

⁴⁹ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль 12 дугаар зүйл. 2005.12.08

Засгийн Газрын тухай хуулийн 19, 28 дугаар зүйл

⁵⁰ Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Газар

⁵¹ Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо

⁵² Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш оролцооны стандарт дүрмийн хэрэгжилт төслийн хүрээнд хийгдсэн ХБИБ-уудын төлөөлөлтэй хийсэн бүлгийн ярилцлагын үр дүн

Мэргэшсэн нийгмийн ажилтан бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрийг магадлан итгэмжлэх, ажил үйлчилгээ явуулах эрх олгох ажиллагааг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран гүйцэтгэдэг байна.⁵³ Одоогийн байдлаар манайд хэд хэдэн их дээд сургууль тэр дундаа улсын хэмжээний томоохон сургуулиудад нийгмийн ажилтан бэлтгэж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей Тогтоол
48/96

19. ХҮНИЙ НӨӨЦИЙН СУРГАЛТ

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой хөтөлбөрүүд болон үйлчилгээнүүдийг төлөвлөхөд болон хэрэгжүүлэхэд хамрагдах бүх түвшний хүний нөөцийг тохирох сургалтад хамруулах ажлыг баталгаажуулах үүрэгтэй.

Мэргэшсэн боловсон хүчнээр сургалт удирдуулах, нарийн мэргэжилтэн бэлтгэх байдал хангалтгүй байгаа бөгөөд 1990 оноос хойш согогзүйч мэргэжилтэн бэлтгээгүй, монголд ийм мэргэжилтэн бэлтгэдэг сургалт байхгүй, одоогоор ажиллаж байгаа согог зүйчид мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж чаддаггүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар хэрэгжиж буй хөтөлбөр, төслүүдийн хүрээнд зарим мэргэжилтэн, боловсон хүчинд сургалт явуулах нь бий бөгөөд тухайлбал: ЭМЯ, Италийн Засгийн газрын бус АИФО байгууллагаас хамтран хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах Тэгш дүүрэн хөтөлбөр”⁵⁴-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, эмч, эрүүл мэндийн дунд мэргэжилтэн, багш, сайн дурынхныг сургалтанд хамруулжээ.

5.8 ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСНИЙ ҮНЭЛГЭЭ БА ХЯНАЛТ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

20. ҮНДЭСНИЙ ҮНЭЛГЭЭ БА ХЯНАЛТ

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш боломжтой холбоотой үндэсний хөтөлбөрүүд болон үйлчилгээнүүдийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, тасралтгүй хяналт тавьж байх үүрэгтэй.

Төрөөс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөрүүдийн үр дүн, хэрэгжилтэд нэгдсэн байдлаар хяналт тавих, үнэлгээ хийх тогтолцоо бүрдээгүй байна.

НХХЯамны хүрээнд яамны үйл ажиллагаанд хяналт тавьдаг дүрэм хөтөлбөрийг ерөнхийд нь авч үздэг чиг үүрэг бүхий ажилтан байдаг ч энэ нь хангалтгүй юм.

Үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд дотоодын болон хөндлөнгийн хяналт төлөвлөгдсөн байдаг ба тухайлбал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах хөтөлбөр⁵⁵ийн хүрээнд тус хөтөлбөрийг зохицуулах зөвлөл нь үндэсний түвшинд үнэлгээ өгөх, удирдан чиглүүлэх хийгээд хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, зохицуулах эрхтэй ажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хөтөлбөрүүд болон үйлчилгээнд үнэлэлт өгөх нэгдсэн шалгуур үзүүлэлтүүд, нэр томъёог боловсронгуй болгох асуудал дээр

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран ажиллах байдал хангалтгүй байна.

2006 оноос Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд төлөвлөлтийн шатанд хяналт хэрэгжүүлэх, зөвлөх үүрэг гүйцэтгэх байдлаар оролцох эхлэл тавигдаж байгаа нь сайшаалтай хэдий ч хяналт хэрэгжүүлэх чадварыг бий болгох асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй байна.

⁵³ Нийгмийн халамжийн тухай хууль 2005

⁵⁴ 1992-1996 онд Нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах хөтөлбөрийн бэлтгэл шат, 1997-2001 он ЕХолбооны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн. 1999 оноос “Тэгш дүүрэн” хөтөлбөр болсон.

⁵⁵ Эрүүл мэндийн сайдын 91 тоот тушаал 2006.04.03

5.9 ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

21. ТЕХНИКИЙН БА ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Улс орнууд аж үйлдвэржсэн болон хөгжиж байгаа орнуудын аль аль нь хөгжиж байгаа орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын нөхцөл байдлыг сайжруулахад арга хэмжээ авах ба хамтран ажиллах үүрэгтэй.

боловсронгуй болгох бодлого, үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулж байгаа бөгөөд Тухайлбал: Италийн Засгийн газрын бус АИФО байгууллагаас ЭМЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах Тэгш дүүрэн хөтөлбөр”, ДАНИДА болон Хүүхдийг ивээх сангийн /Англи/ санаачлага дэмжлэгтэйгээр 2008 он хүртэл хэрэгжүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөр”-ийг дурьдаж болох юм.

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд хамаарах олон улсын тунхаглал, гэрээ конвенц, хөтөлбөрүүдэд нэгдэн орсон байдаг.

Монголын Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд тэр дундаа Хүүхдийн сан, Боловсрол Шинжлэх ухаан Соёлын Байгууллага, ТАСИС, ХИС/Англи/, АДРА, Дэлхийн зөн, Данида, АИФО, ДЭМБ, ОУХБ, АХБ, Японы Ядуурлыг бууруулах сан зэрэг олон улсын байгууллагуудын үүрэг оролцоог өндөрөөр үнэлэх нь зүйтэй юм.

Дээрх байгууллагууд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, боловсрол, нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрх зүйн орчинг

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ

1993 оны 12 сарын 20
НҮБ-ын Ерөнхий Ассамблей
Тогтоол 48/96

22. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш боломжийн бодлогуудын хүрээнд олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох ёстой.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ДҮГНЭЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш оролцооны угтвар нөхцөл хангалттай бүрдээгүй байна.

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүн”-ий тухай одоо ашиглагдаж буй ойлголт нь олон улсын жишигт нийцээгүй бөгөөд энэ ойлголтыг хүмүүст зөвөөр хүргэх төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай судалгааны үр дүн, нийгмийн халамжийн хийгээд даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн бодлого, үйлчилгээнд ч зохих нөлөөг үзүүлж байна. Хөгжлийн бэрхшээл хэмээх ойлголтын хүрээнд 1/. Хараа 2/. Сонсгол 3/. Хэл яриа 4/. Оюун ухаан 5/. Тулгуур эрхтэн 6/. Сэтгэц 7/. Хавсарсан хэлбэрийн чадвар алдалтыг хамруулдаг байхад манайд хөгжлийн бэрхшээлийн чадвар алдалтад дээр дурьдсанаас гадна халдварт өвчин, сүрьеэ, дотрын өвчнүүдийг багтаан ойлгодог байна.⁵⁶
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өөрсдийн адил ойлгож, хүлээн зөвшөөрөх нийгмийн хүлээн авалт бүрдээгүй байна. Монгол Улсын төрөөс олон улсын хийгээд олон нийтийн байгууллагуудтай хамтран тодорхой төсөл хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай нийгэмд зөв ойлголт, хандлага төлөвшүүлэх талаар арга хэмжээг цөөнгүй хэрэгжүүлж байгаа хэдий ч олон нийтийн дунд төдийлөн эерэг нөлөөлөл үзүүлж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, энэ чиглэлээр ажил үйлчилгээ эрхэлдэг ажилтнуудын дунд ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хэрэгцээ, чадамж, хувь нэмрийн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа юм. Олон нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай “нийгмийн тусгай” /23.8%/ хүмүүс бөгөөд нийгмийн зүгээс анхаарал, халамж байнга шаарддаг /47.5%/ гэсэн ойлголттой байна⁵⁷.
- Төрийн хууль тогтоомж, бодлогын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үр дүнтэй эмнэлгийн тусламжаар хангах асуудал тодорхой түвшинд хөндөгдөн орсон ч хэрэгжилтийн хэмжээнд цөөн хэдэн нэр төрөл, чиглэлийн хөтөлбөрөөр хязгаарлагдаж байгаа төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрт энэ үйлчилгээ жигд хүрч чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн таван хүн тутмын хоёр нь, тэдний асран хамгаалагчид, гэр бүлийн гишүүдийн гурван хүн тутмын нэг нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой ажил үйлчилгээ эрхлэгчдийн гурван хүн тутмын хоёр нь л хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авч чаддаг гэжээ⁵⁸.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засалтын үйлчилгээгээр хангах тухай үндсэн харилцаа нь хууль эрх зүйн хийгээд төрийн бодлогын түвшинд баталгаажсан гэж болох ч энэ чиглэлээр хөгжлийн бэрхшээлийн бүх хэлбэрийг багтаасан үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн байдал нь учир дутагдалтай байна. Сэргээн засалт шаардлагатай бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү үйлчилгээг хүртэж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 45.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байдалд шилжихээс өмнөх урьдчилан сэргийлэх үзлэгт, 47.1 хувь нь бие эрхтэний ажиллагааг нөхөн сэргээх эмчилгээнд, 51.4 хувь нь алдагдсан ажиллагааны хязгаарлалтыг нөхөн сэргээх эмчилгээнд 33.1 хувь нь эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээнд огт хамрагдаж байгаагүй ажээ⁵⁹.

⁵⁶ Эрүүл мэндийн сайдын тушаал 250А жагсаалт

Ердийн өвчин, ахуйн ослийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан даатгуулагчид тэтгэврийн даатгалын санаас тахир дутуугийн тэтгэвэр олгож байна. 2006 оны хойрдугаар улирлын байдлаар 50.1 мянган хүний тахир дутуугийн тэтгэвэрт 10.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Улсын Нийгмийн Даатгалын Газар www.ndaatgal.mn

⁵⁷ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь-АИФО, ХБИБҮХ, Консенсус ТББ-2006 төслийн хүрээнд хийгдсэн социологийн судалгааны тайлангаас

⁵⁸ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь-АИФО, ХБИБҮХ, Консенсус ТББ-2006 төслийн хүрээнд хийгдсэн социологийн судалгааны тайлангаас

⁵⁹ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь-АИФО, ХБИБҮХ, Консенсус ТББ-2006 төслийн хүрээнд хийгдсэн социологийн судалгааны тайлангаас

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан туслах хэрэгсэл, үйлчилгээгээр хангах асуудлыг нэр бүхий хуулиудад зааж өгч зохих журам, дүрмээр баталгаажуулж өгсөн ч төсөв санхүүжилтийн хүрэлцээ бага, нийлүүлж буй туслах хэрэгслийн нэр төрөл, чанарын асуудал хангалтгүй байна. Ихэвчлэн Олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хүргэж байгаа ч хүртээмж, хүрэлцээ тэр бүр хангалттай байж чадахгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие бялдарын хийгээд мэдээлэл, харилцааны хүртээмжтэй орчин бүрдээгүй байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, харилцаа холбоог хүртээмжтэй болгох хууль эрх зүйн асуудлыг боловсронгуй болгоход цаашид анхаарах хэрэгтэй байгаа нь холбогдох хууль тогтоомжид хангалттай тусгагдаагүй буюу хэт ерөнхий байдлаар тусгасан байгаагаас харж болох юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан хүргэж байгаа ч энэ нь хүн бүрт хүрэх боломж, нөхцөл бага байгаа бөгөөд өдөр тутмын мэдээ мэдээллийг дохионы хэлний орчуулгатай хүргэх асуудал бүрэн шийдвэрлэгдэж, тогтмолжоогүй байна.
- Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц байхгүй. Сүүлийн жилүүдэд хараагүй болон тэргэнцэртэй хүний зорчих зам, орц, гарцын дуут дохио зэргийг нийслэл хотод цөөн тоогоор барьж байгаа нь сайшаалтай ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бий болгох нь зайлшгүй хэрэгцээ болоод байна. 2004 онд Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” /БД 31-101-04/ -ийг баталсан бөгөөд мөн оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд, насанд хүрсэн хүмүүс боловсролыг интеграцчилсан түвшинд эзэмших байдал хангалтгүй байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай боловсролын хэрэгцээ чухал хэвээр байна. Харьцангуй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хамрагддаг тусгай цэцэрлэг 3, сургууль 6, сургалт үйлдвэрлэлийн төв 1 нийслэл хотод ажиллаж байна. Ерөнхий боловсрол олгодог тусгай сургуулиудаас 4 нь оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгоход түлхүү анхааран ажилладаг боловч стандарт дүрмэнд заасны дагуу хамгийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдийг бүрэн хамруулж чадахгүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр зохих дэвшил гарсан ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйл ажиллагаанд хамрагдах байдал, ердийн сургалттай сургуульд суралцахад нийгмийн хүлээн авалт болон тухайн хүүхдүүдийн сэтгэл зүйн бэлтгэл хангалтгүй байгаа төдийгүй интеграцчилсан сургалт явуулж буй сургалтын байгууллагуудад хүртээмж, туслах үйлчилгээнүүд хүрэлцэхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал тулгамдсан хэвээр байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар /2006 оны нэмэлт өөрчлөлт/ тусгайлан баталгаажуулж өгсөн бөгөөд эдгээр хуульд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авах, ажиллуулаагүй тохиолдолд төлөх төлбөр хийгээд түүний зарцуулалт, ажлын цаг, хөдөлмөрийн нөхцлийн хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх хөнгөлөлт, мэргэжлийн сургалтаар мэргэжил эзэмшүүлэх тухай асуудлыг шийдвэрлэх боломжийг олгожээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрөөс бодлого, хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэхэд анхаарч байгаа ч хөдөлмөр эрхлэх боломжтой олон хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Энэ нь дээрх үйл ажиллагаанууд өргөн цар хүрээг хамарч чадахгүй байгаатай холбоотой, нөгөө талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх сэтгэл хийгээд бие бялдарын хувьд бэлтгэх, нийгмийн хүлээн авалт, үнэлэмжийн асуудал багагүй нөлөөлж байгаа билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр орлого олох болон нийгмийн хамгааллаар хангагдаж чадахгүй байна.

- Монгол улсын хэмжээнд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг буюу хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан, бүрэн хараагүй, хэлгүй, дүлий болон одой хүн, хүний амь аврах, гоц аюулт халдварт өвчний голомтод ажиллах буюу байгалийн гамшиг, осолтой тэмцэж иргэний журамт үүргээ биелүүлж яваад хөдөлмөрийн чадвараа алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон хүн зохих орлоготой байхыг баталгаажуулсан байна. Өөрөөр хэлбэл эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлээс үүдсэн хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгон, дээрх шалгуурыг хангасан хүн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах бөгөөд 2004 онд гаргасан ҮСГ-ийн бүртгэл, түүвэр судалгаагаар Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 11.6 хувь нь буюу 8000 гаруй иргэн эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээ тогтоолгоогүй байв. Түүнчлэн 22.6 хувь нь Нийгмийн халамжийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлдэг хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагддаг гэсэн бөгөөд үлдсэн 77.4 хувь нь буюу 2057 иргэн хамрагдаж чаддаггүй гэжээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандсан нийгмийн хамгааллын чиглэлийн төрийн бодлогод иргэдийг зөвхөн халамжийн тэтгэвэр аваад суухаас илүүгээр ажил хөдөлмөр эрхлэхэд, нийгэм, хамт олны дунд идэвхтэй амьдрах, өөрсдийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг дэмжихэд анхаарсан бодлого хэрэгжүүлэхээр болж үүнийгээ ч зохих хууль, тогтоомжийн хүрээнд баталгаажуулжээ. Хэдийгээр энэ нь хэтийн ирээдүйтэй бодлого ч өнөөдрийн нөхцөл байр сууринд нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг зөрчихгүй байхад чухалчлан цаашид үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд илүү ихээр анхаарах хэрэгтэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүлтэй байж, тэжээн тэтгүүлэх, харгалзан дэмжүүлэх байдал эрх зүйн хүрээнд баталгаажсан байна.

- Хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжийн хүрээнд удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй л биш бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд хувь хүний эрхийн дагуу гэрлэх, гэр бүлийн амьдрал зохиох эрхтэй төдийгүй тэжээн тэтгүүлэх, харгалзан дэмжүүлэх эрх зүйн зохицуулалт хуульчлагджээ. Гэсэн ч хуулийн заалт бодит байдалд хэрэгжихгүй байх нь олонтаа бөгөөд 2004 онд НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр НХХЯ-ны захиалгаар Гал голомт хөдөлгөөний судлаачдын багийн гүйцэтгэсэн “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, цаашдын хандлага” судалгааны дүнгээс үзэхэд өнөөгийн байдлаар хүүхдээ насанд хүртэл тэжээн тэтгэж, хөдөлмөрийн чадваргүй бол насанд хүрсэн хойно нь тэжээн тэтгэх үүргийг эрэгтэйчүүдийн 61.8 хувь нь, эмэгтэйчүүдийн 57.0 хувь нь сайн биелүүлж байгаа гэж үзсэн бол хүүхэд насанд хүрээд эргээд эцэг эхээ тэжээн тэтгэж байгаа байдал сайн байгаа гэж нийт хүмүүсийн тал хүрэхгүй (47.0) хувь нь үнэлжээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн соёл, спортын үйл ажиллагаанд оролцохыг хуулиар баталгаажуулж өгсөн ч бодит байдал дээр энэ нь жигд хүртээмжтэй байж чаддаггүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь Монгол улсын иргэнийхээ хувьд шашин шүтэх, эс шүтэх үндсэн эрх, эрх чөлөөг эдлэх бөгөөд Онц болон дайны байдал зарласан тохиолдолд ч хүний амьд явах эрхийн адилаар итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хязгаарлахыг хориглосон байна. Гэсэн ч эдийн засгийн хувьд дутмаг байдлаас шалтгаалан өөрийн хүсэл, сүсэг бишрэлээр бус байдлаар шашны нөлөөнд орох байдал бий болсон байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар бодитой судалгаа хийхэд нэр томъёо, ойлголтын байдлыг нэн тэргүүнд цэгцлэх, олон улсын жишигт хүргэх нь чухал байна. Өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлын талаар нэгдсэн мэдээллийн сан байхгүй бөгөөд улсын хэмжээнд хийгдсэн судалгаанууд дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо болон нөхцөл байдлын талаарх мэдээллүүд зөрүүтэй байна.
- Үндэсний түвшинд төлөвлөж хэрэгжүүлж буй төрийн бодлогуудад болон ерөнхий хөгжлийн төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлийн асуудлыг ерөнхий байдлаар оруулж өгдөг бөгөөд орон нутгийн түвшинд үйл ажиллагааг дэмжихэд зохих байдлаар анхаардаг байна. Хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн талаар баримталж буй төрийн бодлого хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, төрөөс нэгдсэн байдлаар цогц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэгч салбар нэгж, санхүүжилтын эх үүсвэр, төрийн бус хийгээд олон улсын байгууллагуудын хувь оролцоог тодотгон өгөх хэрэгцээ байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд хамаарах хууль эрх зүйн орчин зохих түвшинд бүрдэж байна гэх боломжтой ч цаашид мөн улам боловсронгуй болгох, салбар хоорондын бодлого, зохицуулалт, хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах тал дээр анхааран ажиллах шаардлагатай байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох үндэсний хөтөлбөрүүд болон арга хэмжээнүүдийн санхүүжилтийн байдалд олон улсын байгууллагууд, хандивлагчдийн үүрэг оролцоо харьцангуй өндөр байна. Хэдийгээр олон улсын байгууллагуудаас санхүүжигдэж байгаа нь төрийн ачааллыг багасгах, төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулахад дэмжлэг болж байгаа ч нөгөө талаар төрийн хариуцлагыг саармагжуулах, биеэ даасан бодлого, үйл ажиллагааг алдагдуулах байдалд хүргэх боломжтой юм гэдгийг анхаарах хэрэгтэй.
- Монголд Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар тэгш оролцооны стандарт дүрмийн хүрээнд байгуулагдсан үндэсний түвшинд үйлчлэх байнгын ажиллагаатай, хууль ёсны Үндэсний зохицуулах хороо буюу түүнтэй ижил төстэй үүрэг бүхий байгууллага одоогоор байхгүй байгаа бөгөөд ийм төрлийн үүрэг бүхий байгууллагын хэрэгцээ байна.
- Манайд өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд цөөнгүй байгуулагдсан ч оюуны хомсдолтой сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах байгууллага байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага нь нэгдсэн зохион байгуулалтад орох нь байгууллагын чадавхи, боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, зорилго, үүргээ биелүүлэх, үр дүнтэй ажиллахад чухал юм. Төрөөс ХБИБ-уудыг шууд дэмжсэн тусламж үгүй бөгөөд 2006 оноос төрийн зохих байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх хуулийн заалтын дагуу ХХҮГазар, НХХЯамтай ХБИБҮХолбоо гэрээ байгуулан ажиллаж зарим ажил үйлчилгээг гүйцэтгэх болжээ.
- Нийгмийн халамжийн тухай хууль /2005/-д зааснаар халамжийн болон асрамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах нь ХХҮГ-т хамаарах бөгөөд төрийн байгууллагуудын хүрээнд хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор ажилтнаа сургалтанд хамруулдаг ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын ажилтныг сургах байдал орхигддог байна. Одоогийн байдлаар манайд хэд хэдэн их дээд сургууль, тэр дундаа улсын хэмжээний томоохон сургуулиудад нийгмийн ажилтан бэлтгэж байна. Мэргэшсэн боловсон хүчнээр сургалт явуулах, нарийн мэргэжилтэн бэлтгэх байдал хангалтгүй байгаа бөгөөд 1990 оноос хойш согогзүйч мэргэжилтэн бэлтгээгүй, монголд ийм мэргэжилтэн бэлтгэдэг сургалт байхгүй, одоогоор ажиллаж байгаа согог зүйчид мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж чаддаггүй байна.
- Төрөөс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөрүүдийн үр дүн, хэрэгжилтэд нэгдсэн байдлаар хяналт тавих, үнэлгээ хийх тогтолцоо бүрдээгүй бөгөөд тухайн хөтөлбөрийн хүрээнд дотоодын болон хөндлөнгийн хяналт, үнэлгээ тусгагдсан байна.
- Монголын Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд тэр дундаа Хүүхдийн сан, Боловсрол Шинжлэх ухаан Соёлын Байгууллага, ТАСИС, Хүүхдийг ивээх сан /Англи/, АДРА, Дэлхийн зөн, Данида, АИФО, ДЭМБ, ОУХБ, АХБ, Японы Ядуурлыг бууруулах сан зэрэг олон улсын байгууллагуудын үүрэг оролцоог өндөрөөр үнэлэх нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ

Төрийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн түвшинд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай ойлголт, нэр томъёоллыг цэгцлэх ✓

- Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх хяналт, үнэлгээ, судалгаанд ашиглагдах шалгуур үзүүлэлтүүд болон ойлголтуудыг боловсронгуй болгох
- Хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрүүдэд байгаа “тахир дутуу” хэмээх үгийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж солих

Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох

- Хууль эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох
- Батлагдсан хуулийг хэрэгжүүлэх дүрэм, журмуудыг бүрэн батлах
- Хуулийн тайлбар гаргах
- Хэрэгжиж буй хуулийн заалт, дүрэм журмын уялдаа холбоо, нийцэх байдлыг сайжруулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх, оролцооны талаарх мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлыг үр дүнтэй зохион байгуулах

- Телевизийн нэвтрүүлэгүүдийг дохионы орчуулгатай явуулах асуудлыг төрөөс тусгайлан дэмжиж санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, хөтөлөгчдийг дохионы хэлний сургалтад хамруулах,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдыг хэрэгцээтэй мэдээллээр хангаж, эрх ашгаа хамгаалах хийгээд төрийн үйлчилгээг хүртэх, төсөл, хөтөлбөрт хамрагдах тухай зохих мэдлэг, ойлголттой болгох ✓
- Олон нийтэд хандсан мэдээлэл, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэхдээ хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчидтэй түлхүү хамтран ажиллах
- Төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, боловсон хүчнийг хууль эрх зүйн хийгээд хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах харилцааны онцлог бүхий тусгай сургалтад хамруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл олж авах боломж, орчны хүртээмжийг сайжруулах
- Халамжийн үйлчилгээ, туслах хэрэгслийг олгодог ч халамжийн тусгай хэрэгслийг хэрэглэх сургалт, хүртээмжийг сайжруулах асуудлыг анхаарах хэрэгтэй

Чадвар алдалтыг тодорхойлох арга аргачлал, хувь хэмжээг боловсронгуй болгох

- Хөдөлмөрийн чадвар алдалтын түвшин 70 буюу түүнээс дээш байгаа тохиолдолд нийгмийн халамжийн бүрэн тэтгэвэр, тэтгэмжид хамруулах
- Хөдөлмөрийн чадвар алдалтын түвшинг тодорхойлж зохих хувь хэмжээгээр тэтгэвэр, тэтгэмжид хамруулах, чадвар бүхий үлдсэн хувьд тохиромжтой ажил хөдөлмөр эрхлэн орлого олох боломжийг нэмэгдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах чадварыг тогтооход анхаарах, “тусгай”-аас –“ердийн” сургалтад шилжих боломжийг судлах, хэрэгжүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэр дундаа хараагүй болон тэргэнцэртэй хүнд хүрэх орчны хүртээмжийг сайжруулах

- “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” /БД 31-101-04/ -ийг стандарт болгох
- Шинээр баригдаж буй барилга, байгууламж, зам, гүүрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан зам, орц, гарц зэргийг зохих стандартын дагуу баримтлах
- Зорчих бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэмэлт үйлчилгээг хөгжүүлэх: хөтөч нохой, дуут дохио г.м.
- Тэргэнцэртэй иргэдэд зориулсан унааны зардлын хөнгөлөлт, тэтгэмжийг асуудлыг шийдвэрлэх

Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 50-аас дээш ажиллагсадтай төсвийн байгууллагын төлөх төлбөрийн төсвийг зохих байдлаар тусгах

Сонгодог хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээнд хамруулах, бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эмнэлгийн тусламж, эмчилгээ, үйлчилгээнд нь түлхүү хамруулах

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёл урлаг, спортын үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлэх, спортын заал, бэлтгэлд шаардлагатай хэрэгслээр хангахад анхаарах, шагнал урамшууллын асуудлыг эргэн харах

ХБИБ-ууд зөвлөх үүргээ хэрэгжүүлэх нөхцөл ба боломжийг баталгаажуулах

Нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд анхаарах, дотооддоо үндэсний мэргэжилтэн бэлтгэх, гадаадад нарийн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах

Нийтийн үйлчилгээний салбарынханд дохионы хэлний сургалт явуулах, ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийтийн үйлчилгээг хүндрэлгүй хүртэх боломжийг нээх

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ерөнхий боловсролд хамруулахаас гадна авъяасыг хөгжүүлэх хөтөлбөр, дугуйланд хамруулахад анхаарах

Үндэсний хяналт, үнэлгээний түвшинд иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх хяналт тавих чадварыг бий болгох

ХБИ-тэй холбоо эрх ашиг бодлогыг хамгаалсан байр суурин дээр хатуу байж хандивлагч, хэрэгжүүлэгчидтэй гэрээ хэлэлцээр байгуулах ёстойгоос эдийн засгийн шахалтаас болж төрийн бодлого, эрх ашиг зөрчигдөх ёсгүй гэдгийг анхаарах

Шинэ бүтээлийг хэрэгжүүлэх, хүлээн авч боловсруулалт хийж, оюуны бүтээлийг бүтээгдэхүүн болгох

Тусгай Илтгэгч Дүрмүүдийг дэмжих, хэрэгжүүлэх, хянах

Төрийн байгууллагын бодлого, шийдвэр, үйлчилгээг хянаж зөв гольдролд нь оруулахын тулд иргэний нийгмийн байгууллагуудыг мэргэшүүлж, хүчирхэг болгох ёстой. Энэ асуудлаар тусгай бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй.

ХАВСРАЛТ

СУДАЛГААНЫ АЖИЛД МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН ОРОЛЦОГЧИД

1. Төрийн байгууллага

- Н.Эрдэнэбаяр НХХЯ-ны ХБИ, өндөр настны асуудал хариуцсан мэргэжилтэн
- н.Оюунчимэг ХЗДХЯ-ны ТББ-ын бүртгэл хариуцсан мэргэжилтэн
- Д.Бямбаа НХХЯ-ны харьяа МССЗҮТ-ийн захирал
- н.Чойжилсүрэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ахлах мэргэжилтэн
- н.Отгонцэцэг НХХЯ-ны харьяа МССЗҮТ-ийн ажилтан

2. Төрийн бус байгууллага

- Д.Тулгамаа Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч
- н.Энхбуянт Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын менежер
- Ц.Оюунбаатар ХБИБҮХ-ны ерөнхийлөгч
- Ц.Батжаргал ХБИБҮХ-ны удирдах зөвлөлийн дарга, ТСХЭАХН-ийн гүйцэтгэх захирал
- П.Төмөрбаатар тэргэнцэртэй иргэдийн “Төмөр” сангийн тэргүүн
- Ц.Энхтуяа “Тахилт” сэргээн засах эмчилгээний төвийн гүйцэтгэх захирал
- Б.Оргодол “Хүмүүн заяа” сонины эрхлэгч
- С.Сайнбаяр “Тахир дутуу иргэдийн холбоо”-ны дарга
- Я.Алтанзагас СХД-ийн ХБИ-ийн салбар зөвлөлийн дарга
- С.Эрдэнэ ХУД-ийн ХБИ-ийн салбар зөвлөлийн дарга
- Н.Билэгсайхан “Мобилити монгол” ТББ-ын тэргүүн
- Ж.Болорцэцэг ХБХЭЭХ-ны гүйцэтгэх захирал
- Я.Авирмэд “Айвуун” гүйцэтгэх захирал
- Ж. Баярмаа БЗД-ийн ХБИ-ийн салбар зөвлөлийн дарга
- Д. Од “Гэгээ мандал” сангийн тэргүүн
- Ю. Бат-Эрдэнэ ХБИБҮХ-ны төслийн ажилтан
- Ц. Мөнхсаруул МХБИХ-ны Улаанбаатар хотын зөвлөлийн дарга

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1946 он
- Тахир дутуу хүмүүсийн эрхийн тухай тунхаглал 1975 он
- Оюуны хомсдолтой хүмүүсийн эрхийн тухай тунхаглал 1971 он
- Тахир дутуу хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрэм 1993 он
- Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт ба тэдний хөдөлмөр эрхлэлтийн тухай 159-р конвенц 1983 он 1998 онд МУ
- Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989 он
- Эдийн засаг, нийгэм соёлын олон улсын пакт, нэмэлт протоколууд
- Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх тухай конвенц 1958 он-1969
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйлдвэрлэлийн орчны тухай конвенц 1981 он
- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц 1979 он

2. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД

- Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хууль 2006 он
- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль 2001 он
- Бага, дунд боловсролын тухай хууль 2002 он
- Барилгын тухай хууль 1998 он
- Биеийн тамир спортын тухай хууль 2003 он
- Боловсролын тухай хууль 2002 он
- Гаалийн тарифын тухай хууль 1996 он
- Гэр бүлийн тухай хууль 1999 он
- Дээд боловсролын тухай хууль 2002 он
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2002 он
- Иргэний бүртгэлийн тухай хууль 1999 он
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдолийг шийдвэрлэх тухай хууль 1995 он
- Монгол улсын иргэний хууль 2002 он
- Монгол улсын үндсэн хууль 1992 он
- Монгол улсын Засгийн газрын тухай хууль 1993 он
- Монгол улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хууль 1993
- Монгол улсын эрүүгийн хууль 2002 он
- Монгол улсын 1999 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын 2000 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын 2001 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын 2002 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын 2003 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын 2004 оны төсвийн тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль 2002 он
- Нийгмийн даатгалын тухай хууль 1994 он
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль 1994 он
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хууль 1994 он
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль 1994 он
- Нийгмийн хамгааллын тухай хууль 1998 он
- Нийгмийн хамгааллын тухай хууль 2005 он
- Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хууль 1998 он
- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль 2005 он
- Өмгөөллийн тухай хууль 2002 он
- Соёлын тухай хууль 1996 он
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль 2000 он
- Төрийн бус байгууллагын тухай хууль 1997 он
- Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль 2002 он

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль 2005 он
- Хөдөлмөрийн тухай хууль 1999 он
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2001 он
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль 1998 он
- Хувь хүний нууцын тухай хууль 1995 он
- Хүн амын орлогын албан татварын тухай хууль 1992 он
- Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль 1998 он
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль 1996 он
- Цэргийн албан хаагчдын тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль 1994 он
- Эрүүл мэндийн тухай хууль 1998 он

3. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /Улсын Их Хурлын 1995.06.08-ны өдрийн 36-р тогтоол/
- Нийгмийн халамжийн тухай хуулиуд, ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай болон тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 1995.12.19-ны өдрийн 89-р тогтоол/
- Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого /Улсын Их Хурлын 2003.05.15-ны өдрийн 16-р тогтоол/
- Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр /УИХ-ын 2003.10.24-ний өдрийн 41-р тогтоол/
- Нийгмийн халамжийн тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2005.12.08-ны өдрийн 77 тоот тогтоол

4. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

- Ази, Номхон далайн орнуудын тахир дутуу хүмүүсийн 10 жилийн ажлын хүрээнд зохиох арга хэмжээний тухай Засгийн газрын 1992.12.18-ны өдрийн 70-р тогтоол
- Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1994.09.28-ны өдрийн 171-р тогтоол
- Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1994.09.28-ны өдрийн 171-р тогтоолын 4-р хавсралт /Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм/
- Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1994.09.28-ны өдрийн 171-р тогтоолын 5-р хавсралт /Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг өмчлөлийн хэлбэрээс үл хамааран 2 хувиар төлөх ажил олгогчийн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний чиглэл/
- “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөр батлах тухай Засгийн газрын 1995.04.10-ны өдрийн 46-р тогтоол
- Тахир дутуу иргэдэд ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх тухай Засгийн газрын 1995.06.28-ны өдрийн 116-р тогтоол (захирамж)
- Хүн амын эрүүл мэндийн боловсрол Үндэсний хөтөлбөр батлах тухай Засгийн газрын 1998.05.01 дүгээр хавсралт /1998-2005 он/
- Нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, үйлчилгээ үзүүлэх тухай Засгийн газрын тогтоол
- Засгийн газрын “Сургуулийн өмнөх боловсрол-2” үндэсний хөтөлбөр батлах тухай 2001.06.05-ны өдрийн 119-р тогтоол
- Засгийн газрын “Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 2001.06.05-ны өдрийн 120-р тогтоол
- Засгийн газрын “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм” батлах тухай 2001 оны 138-р тогтоол
- Засгийн газрын “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах Үндэсний хөтөлбөр” батлах тухай 2001.07.04-ны өдрийн 153-р тогтоол
- Засгийн газрын “Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын дүнгийн тухай 2002.02.08-ны өдрийн 22-р тогтоол (захирамж)
- Засгийн газрын “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр батлах тухай 2002.04.03-ны өдрийн 59-р тогтоол

- Засгийн газрын “Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр” батлах тухай 2002.07.16-ны өдрийн 156-р тогтоол
- Засгийн газрын 2006.05.24-ны өдрийн 118 тоот тогтоолын 5-р хавсралт /“Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт, үзүүлэх журам”/
- Засгийн газрын 2006.05.24-ны өдрийн 118 тоот тогтоолын 6-р хавсралт /“Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын гүйцэтгэх албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам”/
- Засгийн газрын 2006.05.24-ны өдрийн 118 тоот тогтоолын 2-р хавсралт /“Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох журам”/
- Засгийн газрын 2006.05.24-ны өдрийн 118 тоот тогтоолын 3-р хавсралт /“Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх журам”/
- Засгийн газрын 2006.08.16-ны өдрийн 197 тоот тогтоолын хавсралт /“Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр”/
- Засгийн газрын 2006.11.22-ны өдрийн тогтоолын хавсралт /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр/

5. САЙДЫН ТУШААЛ

- Эрүүл мэндийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2003.01.15-ны өдрийн 12 тоот хамтарсан тушаалын хавсралт /Галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, бие эрхтний байдлыг жагсаалт/
- Эрүүл мэндийн сайдын 2003.01.31-ны өдрийн 21 тоот тушаалын 1-р хавсралт /Төлбөргүй тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар/
- Эрүүл мэндийн сайдын 2003.01.31-ны өдрийн 21 тоот тушаалын 2-р хавсралт /Төлбөргүй тусламж, үйлчилгээний жагсаалт/
- Эрүүл мэндийн сайдын 2003.01.31-ны өдрийн 21 тоот тушаалын 3-р хавсралт /Төлбөргүй эм олгох журам/
- Эрүүл мэндийн сайдын 2003.01.31-ны өдрийн 21 тоот тушаалын 4-р хавсралт /Төлбөргүй эм олгох хуудасны загвар/
- Эрүүл мэндийн сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 21/30 тоот хамтарсан тушаалын 1-р хавсралт /Төлбөргүй тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар/
- Эрүүл мэндийн сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 21/30 тоот хамтарсан тушаалын 2-р хавсралт /Төлбөргүй тусламж, үйлчилгээний жагсаалт/
- Эрүүл мэндийн сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 21/30 тоот хамтарсан тушаалын 3-р хавсралт /Үнэ төлбөргүй эм олгох журам/
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2003 74/116 тоот хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт /Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний төлбөр олгох журам/
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2003 оны 74/116 тоот хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт /Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийн жагсаалт/
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2003.12.25-ны өдрийн 435/302/173 тоот тушаалын 1-р хавсралт /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр/
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2003.12.25-ны өдрийн 435/302/173 тоот тушаалын 2-р хавсралт /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлийн бүрэлдэхүүн/
- Эрүүл мэндийн сайдын 2005.05.30-ны өдрийн Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа хөдөлмөрийн тусгай нөхцөл тогтоох заавар, жагсаалтыг шинэчлэн батлах тухай 135-р тушаал
- Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005.06.06-ны өдрийн 137 тоот тушаал
- Эрүүл мэндийн сайдын 2005.07.22-ны өдрийн Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, хөдөлмөрийн тусгай нөхцөл тогтоох заавар, жагсаалтыг шинэчлэх батлах тухай 189 тоот тушаал

- Эрүүл мэндийн сайдын 2006.04.03-ны өдрийн 91 тоот тушаалын 1-р хавсралт /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн/
- Эрүүл мэндийн сайдын 2006.04.03-ны өдрийн 91 тоот тушаалын 2-р хавсралт /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах зөвлөлийн дүрэм/
- Эрүүл мэндийн сайдын 2006.04.03-ны өдрийн 91 тоот тушаалын 3-р хавсралт /Нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хороо ба салбар хорооны дүрэм/
- Эрүүл мэндийн сайдын 2006.04.03-ны өдрийн 91 тоот тушаалын 4-р хавсралт /Зээлийн эргэлтийн сангийн үлгэрчилсэн журм/
- Эрүүл мэндийн сайдын 2006.04.03-ны өдрийн 91 тоот тушаалын 5-р хавсралт /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг илрүүлэх судалгааны болон тайлангийн маягт 1, 2, 3, 4/
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006.06.02-ны өдрийн 55 тоот тушаалын 1-р хавсралт /Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм/
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006.06.02-ны өдрийн 55 тоот тушаалын 2-р хавсралт /Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хөтөлбөр/
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006.06.02-ны өдрийн 55 тоот тушаалын 3-р хавсралт /Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хөтөлбөр/
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006.06.02-ны өдрийн 52 тоот тушаалын 1-р хавсралт /Ажилд зуучлах үйлчилгээг бүртгэх журам/
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006.06.02-ны өдрийн 52 тоот тушаалын 2-р хавсралт /Сургалтын зардал олгох журам/
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006.06.02-ны өдрийн 52 тоот тушаалын 3-р хавсралт /Мэргэжлийн сургалтыг хэрэгцээ, захиалга, гэрээний үндсэн дээр зохион байгуулах журам/
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006.06.02-ны өдрийн 57 тоот тушаалын хавсралт
- Оношлогоо эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт технологи, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын тухай Эрүүл мэндийн сайдын тогтоол

6. НОМ, ГАРЫН АВЛАГА

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам: “Мэдээлэл-Хөдөлмөр эрхлэлт” 2006 он
- Төрийн мэдээлэл: Тусгай дугаар I боть. Монгол улсын олон улсын гэрээ 2004 он
- Ч. Дагвадорж: “Нийгмийн хамгаалал: онол-арга зүй, туршлага, харьцуулалт” 2004 он
- Роберт Хэрон, Барбара Мурэй: “Тахир дутуу иргэдэд хөдөлмөр эрхэлж ажлын байраар хангахад туслалцаа үзүүлэх” /гарын авлага/ 2003 он
- БСШУЯ, Английн элчин сайдын яам, НҮБ-ын хүүхдийн сан, Хүүхдийг ивээх сан /Английн/: “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах бодлого” /гарын авлага/ 2003 он
- Азийн хөгжлийн банк, Японы ядуурлыг бууруулах сангийн дэмжлэгтэй Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл: “Тахир дутуу иргэд ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл”
- Эрүүл мэнд Нийгмийн хамгааллын яам, МУИС-ийн Социологийн тэнхим: “Тахир дутуу иргэдийн нийгмийн хэрэгцээ” /судалгааны дүн, зөвлөмж/ 1999 он
- Хүүхдийг ивээх сан /Англи/, БСШУЯ: “Тэгш хамруулан сургах бодлого” 2004 он
- АИФО, МХБИБҮХ, Консенсус ТББ: “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн судалгааны дүн
- Азийн хөгжлийн банк, Монгол улсын үндэсний статистикийн газар: “Монгол улсын тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл, түүвэр судалгаа, 2004 он” 2004 он
- МУ-ын Засгийн газар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам: “Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг” 2003 он
- НҮБ-ын хүүхдийн сан, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Дэлхийн зөн ОУБ: “Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” /судалгааны тайлан/ 2006 он
- НҮБ-ын Хүн амын сан, Филантропи төв: “Улс орныг дэмжих гурав дахь хөтөлбөрийн хэрэгжилт ба үр дүнд хийсэн судалгааны тайлан” 2006 он

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам: “Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгаалал 2005” тайлан 2006 он
- ХЭҮК, МТДЭХ: “Эмзэг бүлгийн эрхийн талаарх үндэсний болон олон улсын стандарт, хууль тогтоомжуудын эмхэтгэл” 2004 он
- АИФО-Танилцуулга
- Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын боловсролын байгууллага, НҮБ-ын хүүхдийн сан, ДЭМБ: “Хамтарсан баримт бичиг” 2001 он
- Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар: “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн норматив” 2004 он
- Хууль зүйн мэдээллийн төв, Биеийн тамир, спортын үндэсний төв: “Биеийн тамир, спортын холбогдолтой хууль тогтоомжийн эхэтгэл” 1998 он
- “Тахир дутуу иргэдийг дэмжих жил”-ийн хүрээнд хийсэн ажлын тайлан
- “Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”
- “МЭ Консалтинг” ХХК-ийн “Хөдөлмөрийн зах зээлд тахир дутуу иргэдийн оролцоо” судалгааны тайлан